Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ДОРНОД АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /мян.төг/ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | ***Нэг.* Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт** | | | | | | | |
| | *“Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 1.1.1 | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн хэрэгжилтийг зохион байгуулах, дээд газраас ирүүлсэн холбогдох журам, дүрэм, заавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах. | Үйл ажил-лагааны зардлаар | Хэрэгжилтийг зохион байгуулсан журам, дүрэм, заавар, зөвлөмжийн тоо | 2022 онд хэрэгжилтийг зохион байгуулсан журам, дүрэм, заавар, зөвлөмжийн тоо | Хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах, үр дүнг тооцсон байна. | Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолоор тэтгэвэр бодоход баримтлах итгэлцүүрийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан нийт **14500** тэтгэвэр авагчдын тэтгэврийг шинэчлэн тогтоож, тэтгэвэр авагчдын хувийн хэрэгт баталгаажуулан хавсаргав. Мөн ЗГ-ын 239 дүгээр тогтоолын Нийгмийн даатгалын сангаас болон Цэргийн тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлэн бүрэн тэтгэврийн доод хэмжээг 550000 төгрөг, хувь тэнцсэн тэтгэврийн доод хэмжээг 440000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож 07 дугаар сарын 01-ээс мөрдөн ажиллаж байна. Дээрх | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтоолуудын дунд тэтгэвэр тогтоосон цалингийн дундаж 672627 төгрөг, сард олгох тэтгэврийн дундаж **675815** төгрөг болж өссөн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад дундаж цалин **2** дахин, дундаж тэтгэврийн хэмжээ 24 хувиар өсжээ.<br><br>Нийгмийн даатгалын мэдээллийн системийг цогцоор шинэчлэхтэй холбогдуулан гадаадын иргэн, харьяалалгүй 5 тэтгэвэр авагчийн регистрийн дугаарыг Гадаадын иргэн харьяатын газраас олгосон 13 оронтой дугаараар бүртгээд байна.<br><br>“Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2023 оны А/578 дугаар захирамжийн дагуу 10 дугаар сарын 20-ны өдөр аймгийн ЗДТГ-ын байранд ажиллан иргэдийг хүлээн авч Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын талаар мэдээлэл өгч иргэдээс санал хүсэлт хүлээн авч ажиллалаа. Өдөрлөгийн үеэр нийгмийн даатгалын үйлчилгээ болон авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх талаар 80 даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авлаа.<br><br>*(Хавсралт тайлангаар хүргүүлэв)* | | |
| 1.1.2 | Аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчдыг нийгмийн даатгалд хамруулах, | Үйл ажил-лагааны зардлаар | Шинээр хамруулсан ААНБ тоо, даатгуулагчды н тоог суурь | 930 аж ахуйн нэгж байгууллага, 19304 албан журмын | 993 ажил олгогч байгууллага 21040 даатгуулагч | Улсын бүртгэлийн хэлтсээс шинээр бүртгүүлсэн ажил олгогчийн мэдээллийг авч шимтгэл төлөх талаар зөвлөмж, мэдээлэл, боршур бэлтгэн ажилласнаар | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | | түвшнээс 9 хувиар нэмэгдүүл-сэн байна | даатгуулагч | | 69 аж ахуйн нэгжийг шинээр нийгмийн даатгалд хамруулсан байна. Энэхүү үйл ажиллагаатай холбогдуулан аймгийн Татварын хэлтсээс идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй судалгаа авах албан хүсэлт хүргүүлсэн боловч Татварын ерөнхий хуулийн 13.1 дэх заалтын дагуу мэдээлэл өгөх үндэслэлгүй гэсэн хариу ирүүлсэн бөгөөд цаашид энэ тал дээр анхаарал хандуулан ажиллах шаардлагатай байна.<br><br>Тайлант онд 144 аж ахуйн нэгж, 409 албан журмын даатгуулагч нийгмийн даатгалд шинээр хамруулсан байна.<br><br>Мөн өөр аймаг дүүрэгт шимтгэл төлөгчөөр бүртгэлтэй байсан 8 аж ахуйн нэгжийн 104 албан журмын даатгуулагчийг бүртгэж авснаар нийт ***152*** аж ахуйн нэгж, ***513*** албан журмын даатгуулагчийг хамруулсан. | | |
| 1.1.3 | Сайн дураар даатгуулагчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх, малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг 30-с доошгүй хувиар нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, | Үйл ажиллагаан ы зардлаар | Шинээр хамруулсан сайн дураар даатгуулагчды н тоог 10-аас доошгүй хувиар, малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг 30 хувиар нэмэгдүүлсэн байна.хувь | 2022 онд нийт 5263 мянган иргэнийг сайн дурын даатгалд хамруулсан, үүнээс малчин шинээр хамрагдсан | 392 сайн дурын даатгуулагч, 474 малчин даатгуулагч шинээр хамруулсан байна | Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:<br>- Аймгийн төвд байрлах худалдаа үйлчилгээний Шүр зах, Экспо төв болон лангуу түрээслэгч бизнес эрхлэгч 70 гаруй иргэдэд мэдээлэл өгч,<br>- Хэрлэн сумын 10 багийн ажлын албанаас хувиараа хөдөлмөр эрхлэгч-1034, малчин-542, ажил хөдөлмөр эрхлээгүй 4418 иргэдийн судалгааг авч 509 иргэнтэй холбогдон утсаар ярих, мессеж мэдээлэл өгч,<br>- ХХҮГазраас 2020-2023 онд төрсөн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1017 эхчүүдийн мэдээллийг авч үүнээс ажил хөдөлмөр эрхлээгүй, шимтгэл төлдөггүй 286 эхчүүдэд 0-3 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн шимтгэл төлөлт хөнгөлөлтийн талаар мэдээлэл зөвлөгөө өгч,<br>- Жижиг дунд бизнес эрхлэгч иргэдийн уулзалтад оролцон хувиараа гар урлал, оёдол захиалга засвар, үсчин гуталчны засвар үйлчилгээ явуулдаг 66 иргэдэд сайн дурын даатгалын талаар мэдээлэл өгч,<br>- Өмнө нь сайн дурын даатгалын төлж байгаад төлөхгүй болсон ажил хөдөлмөр эрхэлдэггүй 180 гаруй иргэдийн мэдээллийг мэдээллийн сангаас авч холбогдог ажилласан болно.<br>Дээрх ажлын хүрээнд нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 895 иргэнийг шинээр хамруулж 398.722,5 мянган төгрөгийн шимтгэлийн орлогыг нийгмийн даатгалын санд оруулсан байна. Шинээр даатгуулсан сайн дурын даатгуулагчаас 264 малчин даатгуулагч байна. | | |
| 1.1.4 | Туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээ бүхий иргэдэд хууль тогтоомжийг сурталчлах, нийгмийн даатгалд | Үйл ажиллагааны зардлаар | Хөдөлмөрийн гэрээ байгуулж, нийгмийн даатгалд шинээр хамруулсан иргэдийн тоог нэмэгдүүлсэн байна. | 2022 онд нийт 2 иргэн хөдөлмөрийн гэрээ байгуулсан | Шинээр хөдөлмөрийн гэрээ байгуулсан иргэдийн тоо | Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран гэрээгээр мал маллаж хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн судалгаар гаргаж хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсан.<br>Сум тус бүрд багийн Засаг дарга, Хөдөө аж ахуйн тасгийн дарга нартай хамтран малчин айлын мал маллаж туслах малчнаар ажиллаж иргэдийн нийгмийн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хамруулах ажлыг зохион байгуулах | | | | | баталгааг хангах хөдөлмөрийн харилцааг идэвхжүүлж хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар зөвлөмж өгч улмаар нийгмийн даатгалд хамруулах талаар мэдээлэл зөвлөгөө өгсөн.<br><br>2023 онд туслах малчны судалгаанд хамрагдсан **159** иргэдээс **61** малчныг сайн дурын даатгалд даатгуулсан байна. | | |
| 1.1.5 | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн №06 дугаар тогтоолоор баталсан “2023 оны төсвийн хуваарь”-ийн хэрэгжилтийг ханган ажиллах | Үйл ажилла-гааны зардлаар | 2023 оны Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл | Орлого 37 621 037.1 мян.төг, зарлага 89 685 135.7 мян.төг | 626,072.9 мян.төг Орлого 46 348 385.5 мян.төг зарлага 91 110 280.2 мян.төг | Тус хэлтэс нь НДҮЗ-ийн 2023 оны 06 тоот тогтоолоор нийгмийн даатгалын санд *46348385.5 мянган* төгрөгийн орлого төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр *48010250.8 мянган төгрөгийн* орлого төвлөрүүлж, төвлөрсөн орлогыг тухай бүр нь шимтгэл ногдуулалтын хувийг үндэслэн сангуудад хуваарилан ажиллаж байна.<br><br>Харин 2023 оны 07 сард батлагдсан тодотгосон төсвийн хуваариар орлогын төлөвлөгөө 5241616,7 мянган төгрөгөөр нэмэгдсэнээр хүлээгдэж буй гүйцэтгэлээр 93,0 хувийн биелэлттэй гарахаар байна. (*Тодотгосон төсвийн хуваариар сангийн орлого 5241616,7 мянган төгрөгөөр буюу 11,3 хувиар нэмэгдэж батлагдсан нь орлогын төлөвлөгөө 10,4 хувиар буурч гүйцэтгэлд нөлөөлсөн*)<br><br>Сангийн зардал батлагдсан төсвийн хуваарийн дагуу жилийн эцсийн байдлаар 107239382,0 мянган төгрөгийн зардал төсөвлөснөөс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 103760200,0 мянган төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, холбогдох сангуудаас шилжүүлж | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3479182,0 мянган төгрөгийн буюу 3,3 хувиар зардал хэмнэсэн үзүүлэлттэй байна. | | |
| 1.1.6 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн А/07 тоот тушаалаар баталсан “Аймаг, нийслэлийн 2023 онд нийгмийн даатгалд шинээр хамруулах ажил олгогч, албан журмаар даатгуулагч, сайн дураар даатгуулагч, малчдын тооны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах, | Үйл ажиллагааны зардлаар | Батлагдсан тооны төлөвлөгөөний биелэлтийг хангасан байна | 2022 онд 930 аж ахуйн нэгж, байгууллагын 19304 мянган иргэнийг албан журмын даатгалд, 5263 мянган иргэнийг сайн дурын даатгалд хамруулсан | 13,125,614.5 мян.төг<br>101.5 хувь | Тайлант онд 144 аж ахуйн нэгж, 409 албан журмын даатгуулагч нийгмийн даатгалд шинээр хамруулсан байна. Мөн өөр аймаг дүүрэгт шимтгэл төлөгчөөр бүртгэлтэй байсан 8 аж ахуйн нэгжийн 104 албан журмын даатгуулагчийг бүртгэж авснаар бүгд ***152*** аж ахуйн нэгж, ***513*** албан журмын даатгуулагчийг хамруулсан.<br><br>Сайн дурын даатгалыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 0-3 хүртэлх насны хүүхэдтэй “Цалинтай ээж” хөтөлбөрт хамрагдаж буй судалгааг аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас авч судалгааг нэгтгэв. Судалгаагаар :<br>• Ажил хөдөлмөр эрхэлж байгаа 393,<br>• Сайн дурын даатгалын эхийн гэрээтэй 131,<br>• СДД төлөөгүй 366,<br>• 0-3 насны хүүхэдтэй сайн дурын даатгуулагч-126<br>• Регистрийн дугаар буруу 1 даатгуулагч байна.<br>Судалгаанд үндэслэн сайн дурын даатгалд хамрагдаагүй иргэдийн холбогдох дугаарт дуудлага ярьж эхийн нөхцөлөөр шимтгэл төлж 50 хувийн хөнгөлөлт эдлэх тухай мэдээлэл өгснөөр 63 эхийг хамруулсан. Хэрлэн сумын 6 дугаар багийн ажлын албанаас зохион байгуулсан “Явуулын багийн ажлын алба” өдөрлөгт оролцон өнөр хорооллын 19, 22, | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 23, 24, 25 байр, ивээл хорооллын 16,17 дугаар байрны оршин суугчид болон эдгээр байрнуудад хувиараа үйл ажиллагаа явуулж байгаа дэлгүүр, үсчин, гоо сайханчдад нийгмийн даатгалын цахим үйлчилгээ ач холбогдлын талаар мэдээлэл хүргэн, өөрсдийн бэлтгэсэн дансны дугаар, цахим үйлчилгээний талаарх мэдээлэл бүхий гарын авлага тараан зөвлөгөө өгч ажилласан. Төрийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөг”т оролцож иргэд даатгуулагчдад мэдээлэл зөвлөгөө өгсөн.<br><br>Тус хэлтсийн байцаагч ажилтнууд сайн дурын даатгалын талаарх сургалт сурталчилгаагаар нийт 1360 гаруй иргэдэд биечлэн, орон нутгийн хэвлэл мэдээллийн ТВ6 телевизээр 3 удаа, Дорнод сониноор 3 удаа, сошиал орчинд сум тус бүрийн зар сурталчилгааны цахим хуудас, групп хаягаар, аймагт олон дагагчтай Дорнодын ээжүүд, Дорнодын нэгдсэн зар, Дорнод аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс зэрэг цахим хаягт тогтмол пост оруулж ажиллаж байна.<br><br>Үүний үр дүнд 2023 онд 895 сайн дурын даатгуулагчийг шинээр хамруулж, хэлтсийн цахим хуудас нь 7400 дагагчтай болж, өмнөх оноос 200 дагагчаар нэмэгдсэн байна. Энэ үзүүлэлт нь аймгийн агентлагуудаас дагагчийн тоогоор 5-рт, системийн хэмжээнд 3-рт эрэмбэлэгдсэн байна. байна. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ***Хоёр.* Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** | | | | | | | |
| | *“Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 2.1.1 | Шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх | Үйл ажиллагаа-ны зардлаар | Төлөвлөгөөний биелэлт | 38 019 911.09 мян төгрөг буюу 101.28 | 46.348.385.5 мян.төг | Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулиар тайлант онд нийгмийн даатгалын санд 51.590.002,2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсан. Сангийн орлого жилийн эцсийн байдлаар 48.010.250,86 мянган төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, сангийн орлогын төлөвлөгөөг 93,1-107,1 хувиар биелүүлэн ажиллалаа. 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой төсвийн хуваарьт нэмэлт өөрчлөлт орж шимтгэлийн орлогын төлөвлөгөө өмнөх төлөвлөгөөнөөс **5.241.616,7 мянган төгрөгөөр** нэмэгдсэн.<br><br>Дээрх тодотголоор орсон өөрчлөлтөөр шимтгэлийн орлогыг хэт өндөр нэмэгдүүлсэн нь төлөвлөгөө биелэхгүй шалтгаан үүсээд байна. Шимтгэлийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.021.022,0 мянган төгрөг буюу **26,3 хувиар** нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | | |
| 2.1.2 | Эрүүл мэндийн даатгалын санд хуульд заасан орлогуудыг цуглуулах, төвлөрүүлэх, | Үйл ажиллагаа-ны зардлаар | Гэрээний хэрэгжилт | 7 734 56 сая төгрөг | 9.147.880,2 мян.төг | “Хамтран ажиллах гэрээ”-ний хүрээнд ажил олгогч байгууллага, албан журмын даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг 7 хоног болон сар бүрийн сүүлийн өдөр төв санд төвлөрүүлэн ажиллаж байна. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэх | | | | | Мөн эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх малчин хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, оюутан суралцагч иргэдээс 613.374,3 мянган төгрөгийн хураамжийн орлого цуглуулсан байна.<br><br>Тайлант хугацаанд нийт 137 удаагийн гүйлгээгээр 9.373.111,5 мянган төгрөгийг долоо хоног бүр ЭМД-ын санд төвлөрүүлэн ажиллалаа. | | |
| 2.1.3 | Нийгмийн даатгалын сангийн зардлаас давсан орлогыг төв санд төвлөрүүлэх ажлыг хэрэгжүүлэх, | Үйл ажиллагаа-ны зардлаар | 7 хоног бүр төвлөрүүлэх | 15,115,158.8 мян.төг | 19,427,192.9 мян.төг | Нийгмийн даатгалын сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл 15.677.576,0 мянган төгрөгийг тайлант онд нь багтаан Нийгмийн даатгалын ерөнхий газрын төв санд төвлөрүүлж тооцоо нийлэн ажилласан. Үүнд:<br>➢ Тэтгэврийн даатгалын санд *3.050.182,8 мянган төгрөг,*<br>➢ Тэтгэмжийн даатгалын сан *605.500,0 мянган төгрөг,*<br>➢ ЭМД-ын санд *9.373.111,6 мянган төгрөг,*<br>➢ ҮОМШӨ-ний даатгалын санд *2.648.781,6 мянган төгрөг,* | | |
| 2.1.4 | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага бууруулах ажлын төлөвлөгөө гаргаж үр дүнг тооцох | Үйл ажиллагаан ы зардлаар | Авлагын бууралт | 1165,0 сая төгрөг | 466,0 сая төгрөг | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалын дагуу хуримтлагдсан авлагыг бууруулах ажлыг үе шаттай хийх төлөвлөгөө гаргаж хэлтсийн даргаар батлуулсан. Үүнд:<br>• Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Боловсрол шинжлэх ухааны газар, Соёл урлагийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэст шимтгэлийн авлага үүсгэсэн төсөвт байгууллагуудын жагсаалтыг тогтмол | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлж үүссэн авлагыг барагдуулахад хамтарч ажилласнаар 32 байгууллагын 597,115.3 мянган төгрөгийн авлага барагдуулсан,<br>• 31 дээш хоног авлага үүсгэж буй 41 аж ахуйн нэгж байгууллагын удирдлагатай уулзалт зохион байгуулж харилцан тохиролцож хуваарьт гэрээ байгуулснаар 8 ажил олгогчийн 130.574.4 мянган төгрөгийн авлагыг бууруулсан,<br>• Мөн 61 дээш хоног авлага үүсгэж буй 83 ажил олгогчид улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж мэдэгдэл өгч ажилласнаар 384.679,5 мянган төгрөгийн урсгал авлагыг бууруулсан,<br>• Урсгал авлага үүсгэсэн 149 ажил олгогчийн 831.410,9 мянган төгрөгийн авлага барагдуулахаар тухайн байгууллагын банкин дах харилцах дансны зарлагын гүйлгээг зогсоох тухай мэдэгдлийг арилжааны 5 банканд хүргүүлж ажилласнаар 48 байгууллагын 301,699.8 мянган төгрөгийн авлага барагдуулсан,<br>• Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан авлагыг насжилтаар нь тогтмол шинэчлэн гаргаж үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч шимтгэлээ төлөхгүй байгаа 50 аж ахуйн нэгж байгууллагын 575.747,1 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд хариуцагчаар татаж нэхэмжлэл | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гаргаад байна.<br>• Дээрх ажлын хүрээнд 16 ажил олгогчийн 117,431.8 мянган төгрөгийн авлагыг эвлэрүүлэн зуучлалаар дамжуулан үүнээс 6 ажил олгогчийн 77.040,8 мянган төгрөгийн авлага барагдуулж 11 байгууллага нь эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангаагүй тул Шүүхэд нэхэмжлэл гаргаж хариуцагчаар татаад байна.<br>• Үйл ажиллагаа нь зогсож сураггүй алга болсон 4 байгууллагын эздийг тодруулахаар Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд эрэн сурвалжлуулахаар өгсөн. Үүнээс 1 аж ахуйн нэгжийн 799,9 мянган төгрөгийн авлага барагдуулсан байна..<br>• Иргэний хэргийн анхан шатны шүүхийн байгууллагаас шүүхийн захирамж гарч улмаар гүйцэтгэлийг хангаагүй 17 байгууллагын 355,764.5 мянган төгрөгийн хуримтлагдсан авлагаас 178.376,7 мянган төгрөг барагдуулж, 177.387.8 мянган төгрөгийн авлага үлдээд байна.<br><br>Дээрх ажлын үр дүнд 2022 оны жилийн эцэст үүссэн 1,166,037.4 мянган төгрөгийн хуримтлагдсан авлагаас **690,291.7** мянган төгрөгийн авлага барагдуулж гүйцэтгэл **59,2** хувийн биелэлттэй байна. Мөн 2023 онд шинээр үүсэж, хуримтлагдсан **1.112.369,2** мянган төгрөгийн урсгал авлага барагдуулсан байна.<br>Хэдийгээр авлага бууруулах талаарх | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шаардлага тогтмол хийж байгаа боловч аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн нөхцөл байдал | | |
| 2.1.5 | Нийгмийн даатгалын шимтгэлийн бусад өглөг, авлагыг бууруулах | Үйл ажиллагааны зардлаар | Хугацаанд нь барагдуулах | 3651.1 мян.төг авлага, 903.5 мян.төг өглөг | 2555.7 мян.төг авлага, 632.4 мян.төг өглөг | Нийгмийн даатгалын сан хооронд андуурч хийсэн гүйлгээг ташаарсан өглөг үүсгэн, тооцоог холбогдох анхан шатны нотлох баримтыг үндэслэн тухай бүрд нь залруулан ажиллаж байна. | | |
| 2.1.6 | Шимтгэлийн орлогыг төвлөрсөн харилцахаас сангуудад хуваарилах, | Шаардлагагүй | 7 хоног бүр хуваарилах | 37 979 230.0 мян.төг | 46 348 385.5 мян.төг | 2023 оны жилийн эцсийн байдлаар ажил олгогч даатгуулагчаас төвлөрсөн харилцах дансанд хуримтлагдсан 62.273.655,2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг сан тус бүрд хуваарилаад байна.<br><br>Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн урсгалыг зохицуулах ажлын хүрээнд шимтгэл, хураамжийн орлогыг төвлөрсөн харилцах дансанд төвлөрүүлэх, сангуудын орлогыг tg-tusuv программын шимтгэл ногдуулалтын хувийг үндэслэн долоо хоног бүр сангуудад хуваарилан сангийн тогтвортой байдлыг ханган ажиллалаа. Сан тус бүрийн орлого хуваарилалтыг авч үзэхэд:<br><br>Тэтгэврийн даатгалын санд<br>45.343.436,9 мянган төгрөг<br>Тэтгэмжийн даатгалын санд<br>4.526.119,8 мянган төгрөг<br>ҮОМШӨ-ний даатгалын санд<br>3.051.489,9 мянган төгрөг<br>Ажилгүйдлийн даатгалын санд<br>747.464,0 мянган төгрөг<br>Эрүүл мэндийн даатгалын санд | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 8.605.144,6 мянган төгрөгийг тус тус хуваарилсан байна.<br><br>Мөн тайлант улиралд сумдын нийгмийн даатгалын дансанд төвлөрсөн шимтгэлийн орлого болох 11.929.262,9 мянган төгрөгийг сангуудад хуваарилан нийт 1268 удаагийн гүйлгээ бичиж гаргасан байна. | | |
| 2.1.7 | Нийгмийн даатгалын сангийн зардлаас давсан орлогыг төв санд төвлөрүүлэх ажлыг хэрэгжүүлэх, | Үйл ажиллагааны зардлаар | 7 хоног бүр төвлөрүүлэх | 15,115,158.8 мян.төг | 19,427,192.9 мян.төг | Нийгмийн даатгалын сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл 15.677.576,0 мянган төгрөгийг тайлант онд нь багтаан Нийгмийн даатгалын ерөнхий газрын төв санд төвлөрүүлж тооцоо нийлэн ажиллаа. Үүнд:<br>• Тэтгэврийн даатгалын санд 3.050.182,8 мянган төгрөг,<br>• Тэтгэмжийн даатгалын сан 605.500,0 мянган төгрөг,<br>• ЭМД-ын санд 9.373.111,6 мянган төгрөг,<br>• ҮОМШӨ-ний даатгалын санд 2.648.781,6 мянган төгрөг, | | |
| 2.1.8 | Хууль тогтоомжийн дагуу олгогдож байгаа тэтгэвэр, тэтгэмжийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах | Үйл ажиллагааны зардлаар | Хуульд заасан хугацаанд тэтгэвэр тэтгэмжийг олгох | 88 194 185.9 мян.төг | 91 110 280.2 мян.төг | Нийгмийн даатгалын сангийн зардлын батлагдсан төсвийн хуваарийн дагуу 107239382,0 мянган төгрөгийн зардал төсөвлөснөөс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 103760200,0 мянган төгрөгийг тэтгэвэр, тэтгэмжийн сангаас холбогдох зардлуудыг шилжүүлж *3479182,0 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэн үзүүлэлттэй байна*.<br><br>**2023 онд тэтгэврийн даатгалын сангаас** өндөр насны, тахир дутуугийн, тэжээгч алдсаны, цэргийн албан хаагчийн тэтгэвэр | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авч байгаа 14281 тэтгэвэр авагчдад 97.686.022,6 мянган төгрөгийг зарцуулсан. Үүнд:<br>• Өндөр нас 70888372.2 мянган төгрөг,<br>• Тахир дутуу 14668243.9 мянган төгрөг,<br>• Тэжээгч алдсан 3654400.17 мянган төгрөг,<br>• Цэргийн тэтгэвэр авагчдад 8475006.3 мянган төгрөгийн тэтгэвэр тус тус олгож, банкны үйлчилгээний хөлсөнд нийт 5.346,5 мянган төгрөгийг зарцуулсан.<br><br>Хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээнээс илүү төлсөн шимтгэлийн буцаалт авах даатгуулагчийн өргөдлийг үндэслэн 9 иргэнд 2871,5 мянган төгрөгийг шимтгэлийг буцаан олгосон.<br><br>**Тэтгэмжийн даатгалын сангаас:**<br>Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжид 2217 даатгуулагчид 425.648,6 мянган төгрөг зарцуулсан. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэмжийн зардал 9.470,1 мянга буюу 2,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br><br>Жирэмсний болон амаржсаны тэтгэмжид 1267 даатгуулагчид 2.627.965,0 мянган төгрөг, зарцуулсан. Тэтгэмжийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 376.216,8 мянган төгрөг буюу 16,7 хувиар нэмэгдсэн үзүүлэлтэй байна. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Оршуулгын тэтгэмжид 404 даатгуулагчдад 808.000,0 мянган төгрөг, тус тус зарцуулсан байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал оршуулгын тэтгэмжийн зардал 433.000,0 мянган төгрөг буюу 115.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ оноос эхлэн оршуулгын тэтгэмж 2000,0 мянган төгрөг болсонтой холбоотой зардал нэмэгдсэн үзүүлэлттэй байна.<br><br>0-3 настай хүүхэдтэй эхийн тэтгэмжийн сангаас олгох зардалд 149.053,2 мянган төгрөгийн шимтгэлийг зарцуулсан байна.<br><br>**Ажилгүйдлийн даатгалын сангаас:**<br>Ажилгүйдлийн тэтгэмжид хүлээгдэж буй гүйцэтгэлээр 405 даатгуулагчид 1524828,9 мянган төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид олгосон байна. Ажилгүйдлийн тэтгэмжийн зардал өмнөх онтой харьцуулахад 221.484.9 мянган төгрөг буюу 16.9 хувиар нэмэгдсэн дүнтэй байна.<br><br>Энэ оны төсвийн хуваариар ажилгүйдлийн тэтгэмжид нийт 1.166.589,4 мянган төгрөгийн тэтгэмжид төсөвлөгдсөн боловч тэтгэмж авах даатгуулагчдын тоо эрс нэмэгдэж ажилгүйдлийн тэтгэмж олгоход хүндрэл учирсан. Үүнтэй холбоотойгоор дээд газарт нийгмийн даатгалын сангийн төсөвт ажилгүйдлийн тэтгэмжийн зардал нэмж тусгаж өгөхийг хүссэн албан тоот хүргүүлж тухайн сан дотроо зардал хэтрүүлэхгүй байж болно гэсэн хариу авч тэтгэмжийг тухай бүр нь гаргаж | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллалаа. Ажилгүйдлийн сангаас илүү төлсөн шимтгэлийн буцаалтад 767,6 мянган төгрөгийг даатгуулагчдад олгосон байна.<br><br>**ҮОМШӨ-ний даатгалын сангаас:**<br>Тахир дутуугийн тэтгэвэр авагч 48 иргэнд 408326,64 мянган төгрөг, тэжээгч алдсаны тэтгэвэр авагч 11 иргэнд 87472,36 мянган төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 24 даатгуулагчдад 32471,4 мянган төгрөгийг олгосон.<br><br>Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал зардал 12535,7 мянга буюу 2,7 хувиар буурсан байна. Рашаан сувиллын хувьсах зардалд 1425,7 мянган төгрөг зарцуулсан. | | |
| 2.1.9 | Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж үйл ажиллагааны зардлыг үр ашигтай зарцуулж хэмнэлтийн зарчмыг баримтлах , | Үйл ажиллагаан ы зардлаар | Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж өр, авлага үүсгэлгүй ажиллана | 656 696.5 мян.төг | 870 720.0 мян.төг | Тайлант оны үйл ажиллагааны урсгал зардалд 1.062.982,3 мянган төгрөг батлагдсанаас нийт 1.017.834,2 мянган төгрөгийг зарцуулж 45.148,1 мянган төгрөгийг хэмнэн 95.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:<br>• Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, унаа хоолны хөнгөлөлтөд 832.537,5 мянган төгрөг батлагдсанаас 811 230.8 мянган төгрөг,<br>• Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 104.073,5 мянган төгрөг батлагдсанаас 101.403,8 мянган төгрөг,<br>• Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 13.671,8 мянган төгрөг батлагдсанаас 11.565,8 мянган төгрөг, | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Хангамж бараа материалын зардалд 20.942,8 мянган төгрөгөөс 13.949,7 мянган төгрөг,<br>• Эд хогшил урсгал засварын 12.749,4 мянган төгрөг батлагдсанаас 12.661,0 мянган төгрөг,<br>• Дотоод албан томилолтын зардал 7.787,1 мянган төгрөг батлагдсанаас 7.179,6 мянган төгрөг,<br>• Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал 7.425,0 мянган төгрөг батлагдсанаас 7.332,7 мянган төгрөг,<br>• Эмнэлэг хөдөлмөр магадлал комисс, гомдлын шаардлагын зөвлөлийн зардалд 43.354,6 мянган төгрөг батлагдсанаас 34.030,7 мянган төгрөг,<br>• Бусад зардалд 8.204,6 мянган төгрөг батлагдсанаас 6.290,5 мянган төгрөг,<br>• Бусад ажил олгогчоос олгох бусад тусламж дэмжлэгт 12.236,0 мянган төгрөг батлагдсанаас 12.189,6 мянган төгрөгийг тус тус батлагдсан төсөвтөө багтаан эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу зарцуулсан.<br>Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол, 2022 оны 204 дүгээр тогтоолыг тус тус хэрэгжүүлэн зардал тус бүрийг хянаж өглөг үүсгэлгүй зардлын хэтрэлтгүй батлагдсан төсөвтөө багтаан ажил, үйлчилгээг явуулсан болно. | | |
| 2.1.10 | Нийгмийн даатгалын сангийн анхан болон нягтлан бодох | Үйл ажиллагаан ы зардлаар | Мэдээ тайланг үнэн зөв гаргаж, | Нийгмийн даатгалын сангийн | 100 хувь | Сангийн нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтаар хийгдсэн ажил гүйлгээнд үндэслэн бүртгэж харилцах | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бүртгэл хөтлөлтийг тухай бүр хийж, төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг хэрэгжүүлэх | | тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлага, хамралтын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн | | дансны тухай бүрийн дэлгэрэнгүй хуулгатай тулган хянан баталгаажуулж сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг гаргаж байна. Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын сарын мэдээ, өглөг авлагын мэдээ тайланг санхүүгийн программаас хөрвүүлэн сар бүрийн 02-ны дотор илгээн, НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газрын байгууллагын төсвийн гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэнд хянуулж, нэгтгүүлэн ажиллаж байна. Мөн аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст сарын гүйцэтгэлийн мэдээ, өглөг авлагын мэдээг тогтмол хүргүүлж байна.<br><br>Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх хуваарийн дагуу тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэн гаргаж, байгууллагын үйл ажиллагааны тайлантай нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангуудыг хянуулан ажиллаа. Санхүүгийн тайланг үнэн зөв, алдаагүй илэрхийлсэн тухай бодит мэдэгдэл, өр авлага, тооцоо нийлсэн акт, харилцах дансны үлдэгдлийн баталгаа, санхүүжилт төвлөрүүлэлтийн тооцоо хэтрэлт хэмнэлтийн тайлбар зэргийн хамт цаасаар болон файлаар гаргаж НДЕГ т хүргүүлсэн.<br><br>Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланг батлагдсан хуваарьт хугацаанд нь багтаан гаргаж, Сангийн яамны Э-ТАЙЛАН-гийн системд байршуулан гадаад, дотоод хэрэглэгчийг | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээллээр ханган ажиллалаа. | | |
| 2.1.11 | Хэлтсийн эд хөрөнгийн хөдлөл, өөрчлөлт шаардлагатай хөрөнгийн хэрэгцээ төлөвлөлт, хуваарилагдсан хөрөнгийн захиран зарцуулалт хадгалалт хамгаалалт бүртгэлд тусгах зэргийг хэрэгжүүлж ажиллах, | Үйл ажиллагаа-ны зардлаар | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана. | Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайлан мэдээг хагас, бүтэн жилээр тайлагнасан. | Өмч хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд хийж гүйцэтгэн тайлан мэдээг холбогдох газарт хүргүүлсэн байна. | Эд хөрөнгийн тооллого хийх комиссын бүрэлдэхүүнийг хэлтсийн даргын тушаалаар баталгаажуулан байгууллагын эхний хагас болон жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материал, маягт үнэт цаасны тооллогыг тогтоосон хугацаанд зохион байгуулж тайланг Санхүү бүртгэлийн газарт хугацаанд нь хүргүүлсэн байна. Үүнд:<br>- Барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн 9 нэр төрлийн 341926.8 мянган төгрөг,<br>- Авто тээврийн хэрэгсэл 1 ширхэг 69800.0 мянган төгрөг,<br>- Машин тоног төхөөрөмж 42 нэр төрлийн 118943.7 мянган төгрөг,<br>- Тавилга эд хогшил 45 нэр төрлийн 56734.2 мянган төгрөг,<br>- Биет бус хөрөнгө 5 ширхэг 3103.3 мянган төгрөг,<br>- Газар 44000.0 мянган төгрөг нийт 634508.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг байцаагч, ажилтнуудын эд хөрөнгийн бүртгэлийн карттай тулгалт хийж тоолон баталгаажуулсан.<br><br>ТӨБЗГ-ын 2023 оны 122 дугаар тогтоолын дагуу Мэргэжлийн хяналтын газрын хөрөнгөд бүртгэлтэй 3 нэр төрлийн 3,055.0 мянган төгрөгийн үнэтэй /зөөврийн болон ширээний компьютер, принтер/ 2,128.4 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 926.6 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй машин тоног төхөөрөмж, 215.0 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мянган төгрөгийн үнэтэй ширээг тус тус санхүүгийн программд балансаас шилжиж ирсэн хөрөнгөөр бүртгэсэн. НДЕГ-ын даргын 2023 оны тушаалаар бүртгэлд байсан 386 ширхэг нийгмийн даатгалын дэвтэр, 260 ширхэг эрүүл мэндийн гэрчилгээний анхан шатны маягтыг данс бүртгэлээс хассан байна. Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын эд хөрөнгийн бүртгэлийн картад бүртгэлтэй хөрөнгүүдийг санхүүгийн программд үндсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөн, өөрчлөлтийг тогтмол хөтлөн ажиллаж байна.<br><br>Байгууллагын 2022 оны эд хөрөнгийн тооллогын төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн маягтууд /ТӨХ1, ТӨХ2, ТӨХ3, ТӨХ4, ТӨХ5, ТӨХ6, ТӨХ7, ТӨХ11, ТӨ3/, санхүү байдлын тайлан, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээ, тайланг pdf хэлбэрээр тус тус ТӨБЗГ-ын *www.burtgel.pcsp.gov.mn* тооллогын программд 2023 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн дотор оруулж, баталгаажуулан цаг хугацаанд нь илгээсэн.<br><br>Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2022 оны биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдөр ТӨБЗГ-ын мэргэжилтнээр 91 хувьтай дүгнүүлж, өмч ашиглалтын 2023 оны гэрээг 2 хувь үйлдэн байгуулсан байна. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл нь тайлант хугацаанд хийх ажлын төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулж эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эд хариуцагч бүрийн хөрөнгө ашиглалтад хяналт тавьж ажилласан. Байцаагч, ажилтан бүрийн эд хөрөнгийн картад бүртгэлтэй хөрөнгө тус бүрийг программын хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган, ашиглалт, хадгалалт, шилжилт хөдөлгөөн, хамгаалалтын байдалд хяналт тавин ажиллаж байна. ӨХБЗ-ийн гишүүдийн хурлын шийдвэрээр 2023 онд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй, цаашид ашиглах боломжгүй болсон нийт 7 нэр төрлийн 25 ширхэг 18 563.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийн хөрөнгийг ТӨБЗГ-ын тогтоол НДЕГ-ын тушаалын дагуу акталсан байна. | | |
| 2.1.12 | Төсвийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, Аудитын байгууллагаас зөрчилгүй дүгнэлттэй ажиллах | Үйл ажиллагааны зардлаар | Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж акт албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | 100 хувь | 100 хувь | Нийгмийн даатгалын 2022 оны нэгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар ***Зөрчилгүй*** дүгнэлт авсан.<br><br>Тус хэлтсийн даргаар ажиллаж байсан Ц.Батбаярт 2022 онд албан томилолтыг олгохдоо 56,400 төгрөг илүү олгосныг 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр аймгийн Татварын хэлтсийн 100070000952 тоот дансанд төвлөрүүлж, төлбөрийг барагдуулсан актын биелэлтийг Төрийн аудитын газарт албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Мөн шилэн дансны цахим системд | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийгмийн даатгалын сангийн орлого зарлагын 5000.0 мянган төгрөгөөс дээш гүйлгээг PDF хэлбэрээр байршуулсныг нэг бүрчлэн шивж мэдээлэх тухай зөвлөмж өгснийг хэрэгжүүлж байна. | | |
| 2.1.13 | Нийгмийн даатгалын ерөнхий газраас банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, НДЕГ-т хүргүүлэх. | Үйл ажилла-гааны зардлаар | Гэрээний хэрэгжилтийг дүгнэж талууд гарын үсгээр баталгаажуулан холбогдох газарт хүргүүлнэ. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг дүгнэж хүргүүлсэн. | а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах.<br>б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг НДЕГ-т хүргүүлсэн байна. | Банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 2023 онд "Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх, арилжааны банктай хамтрах ажиллах журам”-ыг үндэслэн даатгуулагчдад нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмж төлбөр зардал олгох, сангийн орлого, зарлагын үйлчилгээг банкны байгууллагаар дамжуулан үзүүлэх зорилгоор хоёр талын хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байна. Улмаар сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр тэтгэмж олгох ажлыг саадгүй зохион байгуулж гэрээний дагуу үйл ажиллагааг хэвийн явуулж байна.<br><br>Аймгийн хэмжээнд Хаан банк, Хас банк, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк зэрэг нийт 5 арилжааны банктай хамтарсан гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Мөн тайлант хугацаанд:<br>• Төрийн банкинд - 38<br>• Хаан банкинд - 31<br>• ХХБанкинд - 4<br>• Хас банкинд - 4<br>• Голомт банкинд - 4 нийт 81 данс ашиглагдаж байна.<br><br>Хамтран ажиллах гэрээний дагуу сангийн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | харилцах дансны чөлөөт үлдэгдлийг тооцооны үлдэгдлийн баталгаагаар улирал бүр баталгаажуулан ажиллаж байна. Энэ оны 02 сарын 01-ний өдрөөс эхлэн харилцах дансны өдөр тутмын үлдэгдэлд жилийн 3 хувийн хүүг өдөр бүр хуримтлуулан тооцож арилжааны банктай улирал бүр тооцоо нийлэн хамтран ажиллаж байна. Банкуудтай байгуулсан 2023 оны “Хамтран ажиллах гэрээ”- ний биелэлтийг дүгнэн НДЕГ-т заасан хугацаанд нь хүргүүлэн ажиллаа. | | |
| 2.1.14 | Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санд оруулсан мэдээллийг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх, | Үйл ажиллагаан ы зардлаар | Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ. | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн. | Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | Мэдээллийн системийн шинэчлэлтэй холбоотой ажил олгогчийн мэдээллийг нягтлан засварлаж дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>***УБЕГ-ийн мэдээллийн сантай регистрийн дугаар нь тохироогүй 145 ажил олгогчоос:***<br>- Нийгмийн даатгалын мэдээллийн санд ажил олгогчийн регистрийн дугаарыг буруу бүртгэсэн 133 ажил олгогчийн регистрийн дугаарыг байгууллагын ***opendata.burtgel.gov.mn*** хуулийн этгээдийн мэдээллийн санд бүртгэлтэй эцсийн өмчлөгчтэй холбогдон, байгууллагын гэрчилгээг авч мэдээллийг шинэчилсэн байна.<br>- УБЕГ-т бус өөр байгууллага буюу Татварын хэлтэст бүртгэгддэг сууц өмчлөгчдийн холбоо (СӨХ) нь татвар төлөгчийн дугаараар мэдээллийн баазад бүртгэлтэй байдаг.<br>- Тус хэлтэст бүртгэлтэй СӨХ-ийн удирдлагуудтай холбогдон, холбогдох | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баримт бичгийг ажил олгогчийн хувийн хэрэгт хавсарган ажиллалаа.<br><br>***Нийгмийн даатгалын мэдээллийн санд регистрийн дугаар нь давхардсан 243 ажил олгогчоос:***<br>- Ажил олгогч байгууллагын салбартай, салбаргүй, толгой байгууллага эсэхийг [http://app.ndaatgal.mn:808/ndlav/Login.aspx](http://app.ndaatgal.mn:808/ndlav/Login.aspx) вэб программтай тулган шалгаж, 144 байгууллагын үндсэн мэдээллийг шинэчилсэн байна. Үүнд:<br>***1.*** “Салбар байгууллага” -120<br>***2.*** “Салбаргүй” байгууллага -20<br>***3.*** ‘”Толгой байгууллага” -4<br>- Байгууллагын шилжиж ирсэн, шилжиж явсан хөдөлгөөнийг хянаж шалгалаа. Үүнд :<br>***a.*** Шилжиж ирсэн 80 байгууллага<br>***b.*** Шилжиж явсан 60 байгууллага<br>c. Регистрийн дугаар буруу 4 байгууллагын хөдөлгөөнийг тус тус шинэчлэн ажиллалаа.<br><br>Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дэх заалтын 24.3 дахь хэсэгт заасны дагуу ГИХГ-аас олгосон 13 оронтой гадаадын иргэний регистрийн дугаараар 11 оронтой регистрийн дугаарыг өөрчлөн бүртгэх ажлыг ажил олгогчтой хамтран зохион байгуулан ажиллалаа.<br><br>Шимтгэлийн цахим системд 2023 оны 10 сараас эхлэн гадаад даатгуулагчийг дээрх форматаар өөрчлөн бүртгэж аж ахуйн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэгжийн тайлан хүлээн авч ажиллаж байна.<br><br>НДЕГ-ын даргын 01/1883 тоот “Гадаадын иргэдийн бүртгэлийн дугаарыг өөрчлөх тухай” албан бичгийн хавсралтад аймгийн хэмжээнд 17 байгууллагын 246 гадаад иргэний регистрийг шинэчлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа. Үүнээс үйл ажиллагаа нь зогссон Шанлун ХХК, Энержи трак ХХК, Ундранбэххиж ХХК тус тус байгууллагын гадаад иргэний бүртгэл шинэчлэн бүртгэх боломжгүй байна. Албан бичгийн хугацаанд нийт 144 гадаад иргэний мэдээллийг засахаас 95 гадаад иргэний мэдээллийг шинэчлэн шимтгэлийн цахим системд бүртгэж ажиллаж байна. Мөн тэтгэвэр авагч **ЮД** регистрийн дугаартай 5 иргэний мэдээллийг өөрчилж шинэчилсэн болно. | | |
| 2.1.15 | Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх , | Үйл ажиллагаан ы зардлаар | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас хэрэгжүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэнэ. | Үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлтэй холбоотой зохион байгуулалтын ажилд оролцсон. | Нийгмийн даатгалын сангийн бүртгэл шинэчлэлтэй холбоотой гүйцэтгэлийг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн байна. | Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн зарлагын сарын мэдээ, өглөг авлагын мэдээ тайланг Green ERP программаар, хүний нөөцийн программд нийт 47 байцаагч, ажилтнуудын мэдээллийг шинэчилж, орон тооны гүйцэтгэл, цалингийн тооцооны хүснэгттэй тулгасан мэдээг сар бүрийн 05-ны дотор НДЕГ-ын хүний нөөцийн мэргэжилтэнд тогтмол хүргүүлэн ажиллаж байна.<br><br>Байгууллагын 2023 оны эхний хагас болон жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллого зохион байгуулсан ажлын тайлан, үр дүнг санхүүгийн *GreenErp* программд *Microsoft* | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *Excel* загварын дагуу мэдээллийг бүрэн оруулсан. Байгууллагын барилга, байгууламж, нийтийн эзэмшил, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг 102 ширхэг үндсэн хөрөнгийн мэдээллийн үзүүлэлтүүдийг *Greenfinance* программд бүртгэж оруулсан. Мөн санхүүгийн программын шинэчлэлийг тухай бүрд нь бүртгэн ажиллаж байна. | | |
| 2.1.16 | Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн тооцоогоор үүссэн өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах, | Үйл ажилла-гааны зардлаар | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаа-жуулна. | Авлага,өглөгийн тооцоо нийлж байцаагч тус бүрээр баталгаа-жуулан ажилласан. | Тооцоо нийлсэн актыг үйлдсэн байна. | Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай бичиг хэргийн материал, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, урсгал засварын материалыг гэрээний дагуу холбогдох аж ахуйн нэгж байгууллагуудтай сар бүрийн эцэст тооцоо нийлж, өглөг үүсээгүй байна.<br><br>Маягт, үнэт цаасны тооцоог архив, хөрөнгө хариуцсан ажилтантай улирал бүр батлагдсан маягтын дагуу тооцоо нийлсэн актыг үйлдэж, баталгаажуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газарт хүргүүлж байна.<br><br>Мөн цэргийн тэтгэвэр авагчийн шимтгэл болон бусад нийгмийн даатгалын санд үүссэн өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан санхүүгийн тайлангийн хамт PDF хэлбэрээр байршуулсан болно. | | |
| 2.1.17 | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, өр авлага, хамралтын сарын мэдээ, Нийгмийн даатгалын сангийн | Үйл ажилла-гааны зардлаар | Сар улирлын мэдээ гаргах хуваарийн дагуу тайлан мэдээ иж бүрэн үнэн зөв | 12 удаа | 12 удаа | Сангийн өр авлагын мэдээг сар бүрийн1-ний өдрөөр сумын байцаагчаас хүлээн авч хариуцсан байцаагч нягтлан улмаар Санхүү бүртгэлийн тасгийн даргаар хянуулан хуульд заасан хугацаанд гаргаж | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | санхүүгийн тайлан болон нэгдсэн санхүүгийн тайлан, Plastic тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд гаргаж НДЕГ-т хүргүүлэх | | алдаагүй хийж гүйцэтгэсэн байна. | | | хянуулан ажиллалаа.<br><br>Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн 1-3 дугаар улирлын тайланг санхүүгийн программаар хуулийн хугацаанд үнэн зөв гарган Санхүү бүртгэлийн тасгийн даргаар хянуулж цахимаар илгээн, тайлангийн тодруулга тайлбар, төрийн сангийн дансны үлдэгдлийн баталгаа, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн актын хамт Санхүү бүртгэлийн газарт цаасаар баталгаажуулан хүргүүлсэн. Түүнчлэн сангийн болон байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан мөн нэгтгэсэн санхүүгийн Э-тайланг хугацаанд нь хянуулж, байршуулсан. | | |
| 2.1.18 | Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах , | Үйл ажиллагаан ы зардлаар | Холбогдох заавар журмыг баримтлан хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж төсвийн цагалбарын дагуу хүргүүлнэ | Тооцоо судалгаанд үндэслэн боловсруул-сан төсвийн төслийг тайлбарын хамт хуульд заасан хугацаанд хүргүүлсэн болно. | Хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн үзүүлэлт хоорондын уялдааг хангасан төсвийн санал боловсруулагдсан байна. | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 төсөөллийг төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах заврын дагуу хэлтсийн Санхүү бүртгэлийн тасгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг хийж гүйцэтгэлээ.<br><br>Нийгмийн даатгалын хамрах хүрээ, сангийн орлого зарлагын төсөв төсөөллийг боловсруулахад баримтлах заавар чиглэлийн дагуу сангийн төсвийг төсөвлөсөн.<br><br>Нийгмийн даатгалд бүртгэлтэй шимтгэл төлөгч аж ахуйн нэгж байгууллага заавал болон сайн дураар даатгуулагчдын дундаж цалин хөлс, ажил олгогчийн цалин санг | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өмнөх онуудын дундаж цалин хөлс, урьд жилүүдийн тайлан, цалингийн сангийн гүйцэтгэл, ажил олгогч даатгуулагчийн тооны өсөлт бууралт, тухайн орон нутгийн хүн ам хөдөлмөрийн нөөц ажиллах хүчний мэдээлэлтэй уялдуулан тооцон төсөвлөв.<br><br>Мөн нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн дагуу өндөр насны тахир дутуугийн, тэжээгч алдсаны тэтгэвэр авагчдын тоо, нийт тэтгэвэр авагчдын дундаж тэтгэвэрт зарцуулах хөрөнгийг тооцож төсөвлөв.<br>Байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн төсөл, төсөөллийн саналыг боловсруулахдаа:<br>• Батлагдсан 41 орон тоогоор Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай” 241, “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” орон нутагт ажилласны нэмэгдлийг 20 хувиар 489, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай” 491 дүгээр тогтоолууд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/73 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох дүрэм”-д заасны дагуу мэргэшлийн зэрэг авсан байцаагчдад | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үндсэн цалингийн 10 хувиар, холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн ажилтан бүрээр тооцож төлөвлөлөө.<br>• Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын дагуу нийт ажилтнуудад үндсэн цалингийн 40 хүртэл хувиар улирал бүр олгохоор тооцсон.<br>• ЭХМК-ийн 10 гишүүдийн цагийн хөлсний төсвийг Засгийн газрын 2021 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан ЭХМК-ын дүрмийн 10.1, 10.3 дахь заалтыг үндэслэн 1 цагийн урамшууллын хэмжээг 13095.2 төгрөгөөр, магадлагч эмчийн 3 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг 3 жил жил тутамд олгоно гэж заасны дагуу шаардагдах зардлыг тооцсон.<br>• Өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн 3 албан хаагчдын “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын дагуу шаардагдах зардлыг тооцсон.<br>• Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т заасны дагуу суманд тасралтгүй 5 жил ажиллаж байгаа 5 сумдын байцаагч нарт нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллын зардлыг тооцсон.<br>Бусад урсгал зардлуудыг өмнөх онуудын гүйцэтгэл болон жилийн дундаж хэрэглээ, үнийн тариф, зах зээлийн үнийн дунджийг | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиглан тус тус тооцоолж төсөвлөлөө. | | |
| 2.1.19 | Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллах , | Үйл ажиллагааны зардлаар | Ил тод байдлыг ханган үр ашгийг нэмэгдүүлэн ажиллана. | 15508,2 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан. | Үр ашигтай ил тод байдлыг хanган бодитой байх зарчмыг баримталж ажилласан байна | Төсвийн хэмнэлтийн горимыг сахин хууль тогтоомжийн дагуу зарцуулж ажилласнаас дараах урсгал үйл ажиллагааны зардлуудыг хэмнэн ажиллалаа. Үүнд:<br>- Байр ашиглалттай холбоотой гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны зардалд 13671.8 мянган төгрөг батлагдсанаас 11565.8 мянган төгрөгийг зарцуулж 2106.0 мянган төгрөгөөр,<br>- Бичиг хэргийн зардалд 6417.3 мянган төгрөг батлагдсанаас 5830.4 мянган төгрөгийг зарцуулж 586.9 мянган төгрөгөөр хэмнээд байна.<br>- Ажилтан албан хаагчдыг албан бичгийн төслийг боловсруулж хянуулахдаа, албан хэрэг хөтлөлтийн able программ болон дотоод сүлжээнд цахимаар дамжуулан ашиглаж, бичиг хэргийн материал, бичгийн цаас, принтерийн хорыг хэмнэн ажилласан байна.<br>- Төрийн хэмнэлтийн хуулиар суудлын автомашин ашиглахыг хориглосонтой байгууллагад хамаарсан тул жолоочийн цалин хөлс, автомашины засвар үйлчилгээтэй холбоотой зардлыг гаргалгүй 15.042,2 мянган төгрөгөөр шатахууны зардлыг хэмнэсэн.<br>- Сумдын байцаагч нарыг “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, байцаагч, ажилтнуудын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, харилцаа, хандлага, сэтгэлгээг өөрчлөх, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сурталчлан таниулах” сургалт, газар дээрх хяналт шалгалтыг шаардлагатай тохиолдлоор зохион байгуулахад тус тус томилолтыг зарцуулж, 607.5 мянган төгрөгөөр зардлыг хэмнэсэн байна. | | |
| 2.1.20 | Шилэн дансны мэдээллийн нэгдсэн системд нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг байршуулах ажлыг хэрэгжүүлэх, | Үйл ажиллагаан ы зардлаар | Шилэн дансны цахим хуудсан тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам-ыг баримтлан ажиллана. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Хуулийн хугацаанд мэдээллийг байршуулсан байна. | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийг “Шилэн дансны цахим хуудас” шинэчилсэн хувилбарыг ашиглан 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэх мэдээллийг цаг хугацаанд нь цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.<br>Мэдээллийг сар бүрийн 8-ны дотор, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт нийгмийн даатгалын сангаас олгож буй тэтгэвэр тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарлагын гүйцэтгэлийг оны эхнээс өссөн дүнгээр тухайн хүснэгт маягтын дагуу цахим мэдээлэлд байршуулсан.<br>Сангийн шилэн дансны мэдээлэлд:<br>➢ Сар бүр – 16<br>➢ Хагас жилд – 82<br>➢ Жилд -175<br><br>Шилэн дансны цахим системд жилийн эцсийн байдлаар нийт 175 мэдээлэл байршуулсан. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тухай жилийн батлагдсан төсөв, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын шалгалтаар өгсөн зөвлөмжийн мөрөөр | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн тайлан, батлагдсан орон тооны өөрчлөлт, дараа жилийн төсвийн төсөл, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан 9 албан хаагчдын хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх мэдүүлэг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын үнийн дүнд сар бүрийн үйл ажиллагааны санхүүжилтийн дүн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнд түлш халаалтын дүн, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн дүн, сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, хэлтсийн даргын тушаалын дагуу тусламж дэмжлэгт олгосон мөнгөн дүнг тус тус pdf, хүснэгтэн хэлбэрээр өссөн дүнгээр сар бүр тогтмол хуулийн хугацаанд мэдээллийг байршуулан ажиллаж байна. Үүнд:<br>➢ Тухай бүрд оруулах – 9 мэдээллийг 12 удаа<br>➢ Сар бүр оруулах – 4 мэдээллийг 12 удаа<br>➢ Хагас жилээр оруулах – 4 мэдээлэл<br>➢ Бүтэн жилээр оруулах – 11 мэдээллийг тус тус нийт 171 мэдээлэл байршуулсан байна.<br>Дээрх мэдээллийг нэгтгэж улирлын тайланг тухай бүр илгээж мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллалаа. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.21 | Сайн дурын даатгуулагчдын болон бусад даатгуулагчдын шимтгэлийн тооцооны үлдэгдлийг барагдуулах, | Үйл ажиллагаан ы зардлаар | Үлдэгдэлгүй гарах | 45 202.3 мян.төгрөг | 31 641.6 мян.төг | Сайн дураар нийгмийн даатгалд даатгуулсан хугацаанд албан журмын даатгалд хамрагдан давхар даатгал төлсөн, гэрээний хугацаа дууссан, өндөр насны тэтгэвэр тогтоолгож шимтгэл төлөлтөө зогсоосон зэргээс үлдэгдэлтэй иргэдийн өргөдөл болон холбогдох баримтуудыг хүлээн авч 119 даатгуулагчид 9868,7 мянган төгрөгийн буцаалт олгосон байна.<br><br>Тайлант хугацаанд оны эхний үлдэгдэлтэй 39 даатгуулагчийн өглөгийг даатгуулагч эхийн /hyprid/ тооцоо руу шилжүүлэх жагсаалт үйлдэж оны эхний үлдэгдлийг 2014.9 мянган төгрөг буюу 26,2 хувиар бууруулав. | | |
| | ***Гурав.* Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** | | | | | | | |
| | *“Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 3.1.1 | Малчнаар ажиллаж байсан хугацааг тогтоох “Сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөл”-ийн тогтоолд аудит хийх; | | “Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам”-ыг үндэслэн аудит хийж дүгнэлт гарган, үр дүнг Хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар танилцуулж, баталгаажуула | | Хуулийн хэрэгжилт хангагдаж, зорилтот бүлэгт хүрсэн байна. | Монгол Улсын Засгийн 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 71 дүгээр тогтоолын дагуу аймгийн 13 сумд “Малчинаар ажилласан хугацааг тодорхойлох зөвлөл” байгуулан ажилласан байна. Аймгийн хэмжээнд 2018-2022 онуудад 63 даатгуулагчийн малчнаар ажилласан хугацааг тогтоосон байна. Үүнд:<br>- Хэрлэн 15<br>- Баяндун 8<br>- Баянтүмэн 7<br>- Баян-Уул 6<br>- Булган 2 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | н тайланг 06 дугаар сарын 23-ны өдрийн дотор Дотоод аудит, мониторингийн газарт хүргүүлнэ. | | | - Дашбалбар 2<br>- Матад 5<br>- Халхгол 9<br>- Хөлөнбуйр 5<br>- Цагаан-Овоо 2<br>- Сэргэлэн 2<br><br>Энэ хугацаанд Хэрлэн, Халхгол, Баянтүмэн сумд 7-16 буюу хамгийн их даатгуулагчийн малчнаар ажилласан хугацааг тогтоосон байна. Харин Гурванзагал, Чойбалсан, Чулуунхороот сумдын 1995 оноос хойших мал тооллогын “А” данс нь аймаг, сумын архивд бүрэн хадгалагдсан байгаа тул зөвлөлд хандан шийдвэрлүүлэх шаардлага гараагүй байна. Журмын дагуу сумдын “Малчинаар ажилласан хугацааг тодорхойлох зөвлөл”-ийн баримтууд тухайн суманд хадгалагдаж байсныг хэлтсийн архивд татан төвлөрүүлэн ажилласан. Мөн жил бүр хадгаламжийн нэгж үүсгэн хэлтсийн архивд хүлээлгэн өгч байх зөвлөгөөг нийт сумдын байцаагч нарт үүрэг болгов.<br><br>Цаашид шинээр ажилд орсон сумдын байцаагчдад “Даатгуулагчийн малч-наар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлийн дүрэм”, “Малчинд тэтгэвэр тогтоохоод баримтлах журам”-г танилцуулж байхыг хэлтсийн даргын зөвлөлийн гишүүдэд даалгав. | | |
| 3.1.2 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; | | Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын | | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тухай бүрд хяналт тавьж ажиллав. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг баримтлан, хяналт тавьж хийсэн ажлын тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Дотоод аудит, мониторингийн газарт хүргүүлнэ. | | хангагдаж, мэдээллийг үнэн зөв, хуулийн хугацаанд байршуулсан байна. | Мэдээллийг сар бүрийн 8-ны дотор, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт нийгмийн даатгалын сангаас олгож буй тэтгэвэр тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарлагын гүйцэтгэлийг оны эхнээс өссөн дүнгээр тухайн хүснэгт маягтын дагуу цахим мэдээлэлд байршуулсан байна.<br><br>Шилэн дансны цахим системд жилийн эцсийн байдлаар нийт 175 мэдээлэл байршуулсан. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тухай жилийн батлагдсан төсөв, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын шалгалтаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн тайлан, батлагдсан орон тооны өөрчлөлт, дараа жилийн төсвийн төсөл, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан 9 албан хаагчдын хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх мэдүүлэг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын үнийн дүнд сар бүрийн үйл ажиллагааны санхүүжилтийн дүн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнд түлш халаалтын дүн, | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн дүн, сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, хэлтсийн даргын тушаалын дагуу тусламж дэмжлэгт олгосон мөнгөн дүнг тус тус pdf, хүснэгтэн хэлбэрээр өссөн дүнгээр сар бүр тогтмол хуулийн хугацаанд мэдээллийг байршуулсан.<br><br>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдаж, мэдээллийг үнэн зөв, хуулийн хугацаанд байршуулсан байна гэж дүгнэв. | | |
| | *“Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 3.2.1 | Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу гадаад болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. | | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн төлбөр, зөрчлийн 70.0 -аас доошгүй хувийг барагдуулж ажиллана. | Илэрсэн төлбөр зөрчлийн 95,0 хувийг барагдуулж ажилласан. | Шалгалтын үр дүнг улирал тутамд тооцон, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | НДЕГ-аас ирүүлсэн чиглэл, хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс нийгмийн даатгалын шимтгэл төлдөг болон 1-5 ажилтантай аж ахуйн нэгж байгууллагуудын 2022, 2023 оны санхүүгийн баримтад шалгалт хийлээ. Шалгалтад 18 байгууллага хамрагдлаа. Шалгалтаар салбарын хамтын хэлэлцээрт тусгасан доод хэмжээнээс доошгүй цалинжуулах хүргэж нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд даатгуулагчийн төрөл, ажил мэргэжлийн кодыг зөв тусгах, шимтгэлийн тайланг тоон гарын үсгээр илгээх талаар 6 албан шаардлага хүргүүлсэн. Зарим байгууллагуудын ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заавал тусгах нөхцөлүүдийн талаар ярилцан зөвлөгөө өглөө.<br>Шалгалтын үр дүнд барилгын үйл | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагаа явуулдаг “Их базар” ХХК-ийн ажилтнуудын цалингийн доод хэмжээг 05 дугаар сараас Барилгын салбарын хамтын хэлэлцээрт заасан хэмжээнд хүргэж тайлагнаж эхэлсэн. Мөн “Тал нутгийн сүлд”, “Дорнын мөнгөн сүлд”, “Цагаан сор” ХХК-ууд 6 дугаар сараас ажиллагсдын цалинг нэмэгдүүлэн тайлагнав.<br><br>“Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр 2023 онд хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах 3 шалгуур үзүүлэлтээр 22 аж ахуйн нэгж байгууллагад төлөвлөгөөт хяналт, шалгалтыг төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу уул уурхай болон газрын тосны 11, Барилга угсралтын чиглэлийн 4, Зам тээрийн чиглэлийн 4, Боловсролын 1, Эрчим хүчний салбар 1, бусад 1 хамруулав.<br>Шалгалтаар ажилласан жилийг буруу тооцсон улирлын шинж чанартай ажил гүйцэтгэдэг бөгөөд тодорхой ажилчдын ажиллаагүй байх хугацааны НДШ тооцоогүй, /тухай ажилчид эргэж ажилдаа ороогүй/ Ахмадын сан байгуулаагүй дэмжлэг туслалцаа үзүүлээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хангаагүй зэрэг зөрчил дутагдал нийтлэг байна. Иймд илэрсэн зөрчил дутагдал заавар зөвлөмж өгч улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж зөрчлийг арилгуулан хяналтын хуудсаар эрсдэлийг тооцож ажиллалаа. Нийт 22 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ААНБ-ын мэдээллийг хавсралт хүснэгтээр болон тус бүрийн удирдамжийн хүрээнд тус бүр нь тайлагнаж ирсэн. Салбар бүрийн дундаж эрсдэлийг тооцоход МСҮТ 3.7, Барилга 42.5, уул уурхай 23.9, зам тээвэр 31.2, эрчим хүч 38.5 хувьтай үнэлэгдсэн.<br><br>“Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын 2.7-д заасны дагуу 2023 онд хийсэн объектын эрсдэлийн үнэлгээг үндэслэн Барилга, Уул уурхай, Зам тээвэр, Хөдөө аж ахуй, Худалдаа гэсэн 5 чиглэлээр Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчтай хамтран 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 16 байгууллагын жагсаалтын төслийг хуульд заасан хугацаанд хүргүүлэв. | | |
| 3.2.2 | ЭМНДЕГ-ын даргын 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар баталсан “Тэтгэвэр тогтоож, олгох үйлчилгээний заавар”-ын дагуу тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэрэг, хавсаргасан холбогдох үндсэн баримтын тооллогыг хагас, бүтэн жилд хийж, тэтгэвэр олгосон файл, жагсаалттай тулган шалгаж баталгаажуулах, | | Идэвхтэй, зогсоогдсон, нас барсан тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж үр дүнг тооцож ажиллана. | Жилийн эцсийн байдлаар Улсын хэмжээнд нийт 8,1 мянган тэтгэврийн хувийн хэргийг тоолсон. | ХНХС-ын 2020.12.30-ний өдрийн А/246 дугаар тушаа-лаар баталсан маягтаар актыг 2 хувь үйлдэж, тухайн улирал, жилийн эцэст байвал зохих тэтгэвэр авагчийн тоог хувийн хэрэг, олгосон тэтгэврийн дүнтэй тулган баталгаажуул-сан байна. | Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн 2023 оны төлөвлөгөөний дагуу 3, 12 дугаар саруудад Хэрлэн сумын нийт тэтгэвэр авагчдын хувийн хэргийг массивтай тулган тооллоо. Тооллогоор:<br>• Өндөр насны тэтгэвэр- 6326<br>• Тахир дутуугийн тэтгэвэр-1624<br>• Тэжээгчээ алдсаны тэтгэвэр-413 буюу нийт 8363 хувийн хэрэг бүрэн тоологдлоо.<br><br>Тэтгэвэр авагчдын шилжилт хөдөлгөөн, зогсоогдсон, нас барсан бүртгэлийг тулгахад:<br>• ЗН-НД-9.1 маягтаар шилжиж явсан-129<br>• ЗН-НД-9 маягтаар шилжиж ирсэн-122 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • ЗН-НД-8 маягтаар зогсоогдсон-245<br>• Нас барсан 308, нийт 553 хувийн хэргийг жагсаалт үйлдэн архивд хүлээлгэн өгсөн байна. | | |
| 3.2.3 | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах. | | Зөрчлийн хэрэг бүртгэлийг явуулах, хяналт тавих, эрх бүхий албан тушаалтныг томилж тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажиллана. | Зөрчлийн хуулийн дагуу нийт 119 аж ахуйн нэгж, байгууллагад 7,2 сая төгрөгийн торгууль оногдуулан барагдуулсан. | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хариуцлага тооцож, шийтгэлийн хуудсаар төлүүлэхээр шийдвэрлэсэн торгуулийг 100 хувь, шимтгэл, алдангийг 70-аас доошгүй хувиар барагдуулсан байна. | Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны дагуу зөрчлийн шинжтэй 90 гомдол мэдээллийг хүлээн авч, хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулж 84 байгууллага, иргэний зөрчилд хялбаршуулсан журмаар зөрчлийг шалган шийдвэрлээд байна.<br><br>Хяналт шалгалт хийх явцад зөрчлийн шинжтэй 6 үйлдэлд Зөрчлийн тухай хуульд заасан гомдол мэдээллийг хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн байсан тул зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүйгээр гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзсан шийдвэр гаргасан.<br><br>Зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн ажиллагаанд 84 аж ахуйн нэгж байгууллага, иргэнд 9,0 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчлийг 100 хувь бүрэн барагдуулсан. | | |
| 3.2.4 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/50 дугаар тушаалаар баталсан “Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын дагуу цахим мэдээлэлд тулгуурлан хийх хяналт, шалгалтыг | | Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб программ”-(http://10.9.0.5/monitoring)-д тулгуурлан хяналт, шалгалтыг сар бүр тогтмол | Цахим хяналт, шалгалтыг тогтмолжуулж алдаатай байх магадлалтай мэдээллийн 77,0 хувийг шалгаж, залруулсан. | Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб программ”-(http://10.9.0.5/monitoring)-аас тодорхой өгөгдлийн дагуу шүүлт хийж, зөрчилтэй байх магадлалтай | Нийгмийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлт, зардлын гүйцэтгэлд тавих илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай шийдвэрлэх “Цахим хяналтын веб программ”-ыг ашиглан өгөгдсөн мэдээл-лийн дагуу дотоодын хяналт шалгалтыг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тухай бүрд нь хийж, хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Тухайлбал:<br>- Цалин өөрчилсөн 73 даатгуулагчийн зөрүүтэй мэдээллийн 62 даатгуулаг- | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтмолжуулах, | | хийж "Цахим хяналт, шалгалтын ажлын заавар"-ын 3.4-т заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ. | | мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шалгаж шийдвэрлэсэн байна. | чийн мэдээллийг шалгаж 84,9 хувийн гүйцэтгэлтэй.<br>- 01 код давхардсан 702 даатгуулагчийн зөрүүтэй мэдээллийн 301 даатгуулагчийн мэдээлэл шалгаж 42,8 хувийн гүйцэтгэлтэй.<br>- РД нэгтгэсэн 43 даатгуулагчийн зөрүүтэй мэдээллийн 36 даатгуулагчийн мэдээлэл шалгаж 83.7 хувийн гүйцэтгэлтэй<br>- Цалин өөрчилсөн 596 даатгуулагчийн зөрүүтэй мэдээллийн 408 даатгуулагчийн мэдээлэл шалгаж 80 хувийн гүйцэтгэлтэй<br>- Жирэмсэн амаржсаны цалин хянах, эрхийн нөхцөл жагсаалтад 125 даатгуулагчийн зөрүүтэй мэдээллийн 106 даатгуулагчийн мэдээлэл шалгаж 84,8 хувийн гүйцэтгэлтэй.<br><br>Зөрчилтэй мэдээллийг хянасан 2023 оны нэгдсэн тайлангаар нийт 2565 иргэнтэй холбоотой мэдээллийг шалгаж 80.3 хувийн гүйцэтгэлтэй байна. | | |
| 3.2.5 | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар | | Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн болон жилийн тайланг Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу, НДЕГ-аас | Нийт илэрсэн 46,1 сая төгрөгийн төлбөр зөрчлийн 95,1 хувь буюу 43,8 сая төгрөгийг барагдуулсан. | Шалгалтын үр дүнг хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг | Хэлтсийн дотоод хяналт шалгалтаар өнгөрсөн оны тэтгэврийн олголт, шилжилт хөдөлгөөн, нас баралтад шалгалт хийж 24 хүнд холбогдох 7,6 сая төгрөгийн илүү олголт, 18 хүнд холбогдох 5,3 сая төгрөгийн дутуу олголтыг илрүүлэн Улсын байцаагчийн акт тогтоож бүрэн барагдуулаад байна.<br><br>Иргэд, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдолд үндэслэн 90 байгууллага, иргэнд | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд хүргүүлэх, | | болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг улирал тутамд гаргаж Хяналт, шалгалтын газарт хүргүүлнэ. | | барагдуулсан байна. | Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаагаар 83,4 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж 31,7 сая төгрөгийн алданги, 9,0 сая төгрөгийн торгууль тооцож бүрэн барагдуулав.<br><br>Дотоодын хяналт, шалгалтын хагас, бүтэн жилийн тайланг үнэн зөв гаргаж тайлант хугацаанд хүргүүлэн ажиллав. | | |
| | ***Дөрөв.*** ***Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | | |
| | *“Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 4.1.1 | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас | | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлж, хариуг хугацаанд нь хүргүүлнэ. | НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг гарган тухай | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2022 оны 203, 204 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын 122 дугаар тогтоол болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг тус тус үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>НДЕГ-ын даргын баталсан 2023 оны нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, үйл ажиллагааны урсгал зардлыг батлагдсан төсөвтөө багтаан эдийн засгийн зориулалтын дагуу зарцуулж | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх. | | | бүр хүргүүлсэн. | | байна. Хэлтсийн дотоод үйл ажиллагаатай холбоотой дээд газраас ирсэн хариутай нийт 64 судалгаа, мэдээллийг хүснэгт, pdf хэлбэрээр цахим болон цаасаар цаг хугацаанд нь биелэлтийг хүргүүлэн ажиллалаа.<br>• Сар бүрийн 2-ны дотор төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээ, харилцах дансны үлдэгдэл зэрэг 5 төрлийн мэдээг нийт 12 удаа,<br>• Авлага барагдуулалтын мэдээг сар бүрийн 15-ны өдөр 12 удаа,<br>• Долоо хоног бүрийн Мягмар гаригт авлага барагдуулалтын ажлын мэдээг 40 гаруй удаа,<br>• Эрүүл мэндийн даатгалын газар эрүүл мэндийн даатгалын орлого хамрагдалтын мэдээг сард 2 нийт 24 удаа,<br>• НДЕГ-ын даргын А/07, А/16 дугаар тушаалын биелэлтийг 6 удаа тус тус гаргаж байршуулсан болно.<br><br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2023 оны 03 сарын 03-ны өдрийн 06/428 тоот “Урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт хийх нэгдсэн удирдамж”-ийн дагуу Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгон авч байгаа иргэд, мөн Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тогтоолгон давхардуулан авч байгаа эсэхийг шалгав.<br><br>Шалгалтаар нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авагч өндөр нас, тахир дутуу, | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэжээгчээ алдсан, одой нийт 1552 иргэдийн нэрсийг нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 14178 иргэний жагсаалттай нэг бүрчлэн тулгаж 230 иргэний давхардлыг илрүүлж ажилласан. Үүнээс өндөр насны болон тахир дутуугийн 31 иргэний тэтгэвэр давхардаж 8,2 сая төгрөгийн зөрчлийн халамжийн санд төвлөрүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож ажиллалаа.<br><br>Салбарын хяналтын хүрээнд нийгмийн халамжийн санд урьдчилан сэргийлэх шалгалт хийв. Хэрлэн сумын хэмжээнд 1794 иргэн 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх эцгийг нэг бүрчлэн Нийгмийн даатгалын хэлтэст ЛАВ программд тулгалт хийж давхардлыг гаргаж ирсэн. Энэ нь тухай эх хүүхдээ харж байх хугацаандаа урамшуулал орсон тохиолдолд 68 кодтой байх бөгөөд ААНБ нь ажилд орсон эхийг 68 кодоор оруулж давхардал үүсгэсэн байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэн 70 кодтой тул халамжийн программ хүлээж авч зогсоогддоггүй байна.<br>➢ Тусгай зөвшөөрөлтэй ААН нэгжийн үйлчилгээний чанар муудсан. Жишээлбэл сонсголын аппарат тусгай хэрэгсэл тоног төхөөрөмж чанарын шаардлага хангахгүй.<br>➢ Төсөл зээл хүрэх эзэндээ хүрдэггүй<br>➢ ӨН тэтгэвэр 4, ХБИ 3, ТА 1, байнгын асаргаа 1, бүтэн өнчин хүүхдийн асаргаа 1 анхан шатны бүрдэл болох хувийн хэрэг байхгүй зөрчлийн ХБИ зөрчил арилсан бусад зөрчлүүд арилаагүй, хаяг утсандаа | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байхгүй иргэд байна.<br>➢ Удирдах дээд байгууллагын дотоод хяналт шалгалтын зохион байгуулалт төлөвлөлт хангалтгүй.<br>➢ Өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэрээр түүвэрчлэн очиж тусгай хэрэгсэл үзэхэд хүүхдийн хөлийн согог засах гутал шаардлага хангахгүй энгийн гутал олгосон, суултуур шаардлага хангахгүй, тэргэнцрээ хэрэглээгүй 2 жил болсон, бүс болоод бусад хэрэгслийг бусдад өгсөн шилжүүлсэн зэрэг зөрчлүүд байна.<br>➢ Амьжиргааг дэмжих зөвлөлийн урамшуулал бага, нийгмийн даатгал тооцдоггүй. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж цалинтай ээжийн ажилдаа орчоод халамжийн сангаас давхардаж авсан 6,2 сая төгрөгийг буцаан санд төвлөрүүлэх үүрэг өгч ажиллалаа.<br><br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021-2022 оны бүрдүүлэлт, зарцуулалтад төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийв. Нийгмийн хамгааллын хяналтаар илэрсэн зөрчлүүд, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлууд нь зориулалт бусаар ашигласан хуурамч баримт бүрдүүлсэн байх магадлал, төсөл хөтөлбөрүүд эзэн холбогчдодоо хүрээгүй, баримтгүй гүйлгээ гарсан, нэг байгууллагад давуу эрх олгож | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | олон төрлийн дэмжлэгүүдийг олгосон, цар тахлыг далимдуулж хэрэгслүүд авсан гэх боловч тодорхойгүй, хөтөлбөр төсөлд зориулсан гэх бензин бичиг хэргийн зардлууд их зарцуулагдсан, хүний бичиг баримтыг ашигласан, өнгөрсөн оны баримт хуулбарлаж бүрдүүлсэн, танил тал найз нөхдийг хамруулсан, хүний лангуу дэлгүүр үзүүлж эргэн төлөгдөх чадваргүй хүнд олгож өр үүсгэсэн, хөтөлбөр төсөлд хамрагдсан иргэнээс 50 хувь буцаан авсан зэрэг зөрчлүүд илэрсэн. Дээрх зөрчил дутагдлууд болоод өмнөх онуудын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд байгууллагын зүгээр удирдлагын зүгээс авсан арга хэмжээ байхгүй байна. Иймд ашиглал, зориулалт бусаар үйлдсэн зөрчлийг дахин давтагдуулахгүй байхын тулд, төсвийн хөрөнгийг хуулийн дагуу зарцуулж ажиллуулахын тулд 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 392 албан тоот бичгээр Цагдаагийн байгууллагад хүргүүлж шилжүүллээ.<br><br>Хил хамгаалах ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Монгол Улсын Хилийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хил хамгаалах байгууллагын албан хаагч, улсын хил дээр алба хааж байгаа офицер, ахлагч нарын ажил | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрхлээгүй гэр бүл, Хилийн цэргийн сургуульд сонсогчоор суралцсан болон хугацаат цэргийн алба хаасан иргэдийн хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг баталгаажуулах чиглэлээр Дорнод аймагт байрлах хилийн цэргийн */0132, 0198, 0275, 0306 дугаар/* ангиудтай хамтарсан ажлын хэсэг байгуулан, 2023 оны 03 дугаар сараас зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган, ажлын хэсгээс холбогдох зөвлөмжийг өгч ажиллаж байна.<br><br>Энэхүү ажлын хүрээнд Хилийн цэргийн 0198-р ангид 1995-2005 онд хугацаат цэргийн албан хаагчдын нийгмийн даатгалын шимтгэл нь нийт дүнгээр төлөгдсөн боловч даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалтын тайлан хийгдээгүй байсныг хадгаламжийн нэгж нөхөн бүрдүүлэх журмын дагуу бүртгэж, 193 хуудас баримтыг хэлтсийн архивд нөхөн бүрдүүлэн хүлээж аваад байна. Мөн хилийн цэргийн анги, салбаруудтай хамтарсан хяналт, шалгалтын хүрээнд байгууллагын санхүүгийн болон шимтгэл төлөлтийн тайлан, ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлсний сан, ажилтан, албан хаагчдын хамрагдалтыг холбогдох үндсэн баримтад тулгуулан шалгаж, илэрсэн зөрчлийн хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажиллаа.<br><br>Санамж бичгийн хэрэгжилтэд талууд холбогдох хууль тогтоомжийг удирдлага | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болгон 4 цэргийн ангид улсын байцаагчийн 6 актаар 59 албан хаагчийн төлөгдөөгүй 7,9 сая төгрөгийн шимтгэлийг нөхөн төлүүлж ажилласан хугацааг тогтоогоод байна. | | |
| 4.1.2 | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2022 онд 88,1 %-тай хэрэгжсэн байна. | Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах төв”-д болон иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, тэдний тавьсан санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах. | Тайлант ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн 19 хүсэлтийг шийдвэрлэн ажилласан. Үүнд:<br>- Даатгуулагчийн төрөл засах 23<br>- ХХТАО засах 15<br>- Тоон гарын үсгээр тайлан алдаа өгснийг буцаах, засах 6 хүсэлтүүдийг тасгийн даргын зөвшөөрлөөр мэдээллийн санд засаж оруулаа.<br>Сайн дурын даатгуулагчаас илүү төлсөн данс андуурсан эрүүл мэндийн даатгалыг давхар төлсөн зэрэг өргөдөл хүсэлт холбогдох нотлох баримтад үндэслэн 191 даатгуулагчийн мөнгийг харилцах данснаас гаргаж шийдвэрлэсэн байна.<br><br>Хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээнээс илүү шимтгэл төлсөн 16 даатгуулагчийн өргөдөл хүлээн авч холбогдох нотлох баримтад үндэслэн мэдээллийн баазад журналын бичилт үүсгэж 4782.4 мянган төгрөгийг буцаан олгосон болно.<br><br>ҮОМШӨ улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж тэтгэвэр авч буй 7 иргэний рашаан сувилалд амарсан тооцоог үндэслэн 2067.7 мянган төгрөгийг сангаас олгосон байна.<br><br>Төрөөс нийгмийн даатгалын талаар | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баримтлаж буй бодлого, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй хүргэх, хууль сурталчилах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэн ажиллаж байна.<br><br>Аж ахуйн нэгж байгууллага, иргэд, даатгуулагчаас 92 өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авч шийдвэрлэв. Бичгээр ирүүлсэн өргөдлийг төрлөөр нь ангилбал:<br>➢ Хүүхдээ асарч буй эхийн нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй 6<br>➢ Өвчтэй байх хугацааны шимтгэл төлөөгүй 2<br>➢ Сайн дурын гэрээний хугацаандаа шимтгэл төлөөгүй 44<br>➢ Хугацаат цэргийн алба хаасан хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй 1<br>➢ Нийгмийн даатгалын шимтгэл дутуу төлсөн буруу орхигдуулсан 39<br>➢ Тэтгэвэр тэтгэмж болон нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар зөвлөгөө мэдээлэл авсан 85<br><br>Дээрхи өргөдөл, гомдлыг хүлээн авч холбогдох хууль, тогтоомжийн дагуу хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэж ажиллалаа.<br><br>Хэлтсийн дэргэдэх Гомдлын шаардлагын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 5 гишүүн, 1 нарийн бичгийн даргын Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тушаалаар 2023 оны 01 дүгээр сард шинэчлэн баталсан.<br><br>Гомдлын шаардлагын зөвлөлд 8 даатгуулагчаас ирсэн гомдлыг 8 удаагийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнээс хөдөлмөрийн нөхцөл тогтоох 3, жирэмсэн амаржсаны тэтгэмж нөхөн олгох 1, шимтгэл нөхөн төлүүлэх 2, малчнаар ажилласан хугацааг тогтоолгох 1 өргөдөл хүлээн авч нийт 5 даатгуулагчийн өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэж, 3 даатгуулагчийн гомдлыг хэрэгсэхгүй болгож буцаасан байна. | | |
| 4.1.3 | Нийгмийн даатгалын байгууллагын салбарын хэмжээнд архивын үйлчилгээг сайжруулах, ажил олгогч, иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх. | | Нийгмийн даатгалын хэлтэс дотооддоо болон хэлтсүүд хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгуулна. | Архивын лавлагааг цахимаар солилцох боломжийг бүрдүүлсэн байна. | Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн байна. | Дорнод аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн архивд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23.2-т заасан чиг үүргийн дагуу байгууллагын үйл ажиллагаатай холбоотой удирдлагын байнга болон түр хадгалах, 70 жил хадгалагдах аж ахуй нэгжийн болон, даатгуулагчийн шимтгэл төлөлттэй холбоотой баримт хадгалагдаж байгаа бөгөөд хадгаламжийн нэгжийг нөхөн баяжуулах, мэдээлэл лавлагааны сан бүрдүүлэх, тоо бүртгэл хөтлөх, архивын баримтыг байцаагч ажилтнууд болон хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу бүртгэл хөтлөн ашиглуулах, байгууллага иргэдэд тус хуулийн 2.1.7-д заасанаар цаасан суурьт болон цахим мэдээллийн сангаас лавлагаа мэдээллээр үнэ төлбөргүй үйлчлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх ажлын хүрээнд “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай” хууль, холбогдох журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.<br><br>Мөн “Нийгмийн даатгалын байгууллагын архиваас лавлагаа олгоход баримтлах зөвлөмж”-ийн дагуу 2023 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс ирсэн архивын лавлагаа авах хүсэлтийн дагуу QR код бүхий цахим лавлагааг олгон хэлтэс дотооддоо болон бусад аймаг, дүүргийн хэлтэс хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгууллаа.<br><br>Нийгмийн даатгалын цахим мэдээллийн сангаас 1860 даатгуулагчид, хэлтсийн архивын цаасан суурьтай баримтаас 455 иргэнд хүсэлт гаргасан оны тоогоор лавлагаа гаргасан. Үүнээс 43 лавлагааг 4 аймаг, 4 дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлж ажилласан байна.<br><br>Өнгөрсөн онд хэлтэс, тасаг, сумдын байцаагчаас албан, хэрэг хөтлөлтийн явцад үүссэн буюу аж ахуйн нэгж, даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тайлан тооцоо, тэтгэвэр, тэтгэмжийн олголт болон сангийн холбогдох 296 хадгаламжийн нэгж, тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаад зогсоогдсон 623 тэтгэвэр авагчийн хувийн хэргийг бүртгэлд оруулан энэ оны I улиралд багтаан нөхөн бүрдүүлэлт хийсэн. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн энэ онд нөхөн бүрдүүлэлтээр Батлан хамгаалахын төв архиваас Зэвсэгт хүчний 085 дугаар ангийн 1995-1996 оны ажиллагсдын шимтгэл төлөлтийн 2 хадгаламжийн нэгж, Хил хамгаалах ерөнхий газрын архиваас хилийн цэргийн 0198 дугаар ангийн 1995-2000 оны хугацаат цэргийн албан хаагчдын нэрс 193 хуудас ирснийг 11 ширхэг хадгаламжийн нэгж үүсгэн архивд хүлээн авлаа. 2024 оны 1-р улиралд багтаан данс бүртгэлд оруулан бүртгэнэ. | | |
| 4.1.4 | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, Төрийн албаны тухай хууль тогтоомж, журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргаж байх. | | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, тайланг үнэн зөв гаргаж хүргүүлнэ. | Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах боломжоор хангасан байна. | Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргаж НДЕГ-т Тамгын газарт тайлагнасан байна. | Сүүлийн хагас жилийн хугацаанд Баян-Уул, Чойбалсан сумын байцаагч, бичиг хэрэг, хүний нөөцийн ажилтан нийт 3 албан тушаалын сул орон тоотойгоор үйл ажиллагаа явууллаа. Сул орон тоог Төрийн албан зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын дагуу Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлж сонгон шалгаруулалт явуулах хүсэлт гаргасан боловч жилийн эцсийн байдлаар Чойбалсан сум, сургалт сурталчилгаа, мэдээллийн ажилтны орон тооноос бусад орон тоо нөхөгдөөгүй байна.<br><br>Нийгмийн даатгалын үйлчилгээг хэвийн явуулах зорилгоор сул орон тоог нөхөгдөх хүртэл Баян-Уул суманд ахмад ажилтан Б.Доржхандыг хэлтсийн даргын тушаалаар томилон ажиллуулж байна. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.5 | Хэлтсийн дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх | | Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлол-тоор заагдсан чиг үүрэг, ажлын байрны үндсэн зорилтыг давхардуулахгүй байх, ажлын байрны гол үйл ажиллагааг тодорхой болгох. | Хэлтсийн ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байна. | Хэлтсийн дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлсэн байна. | Хэлтсийн дотоод ажлыг сайжруулах тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах ажлын хүрээнд доорх ажлыг зохион байгуулав. Үүнд:<br>❖ Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Нийгмийн даатгалын багц хуулийн төслийн ээлжит хэлэлцүүлгийг 2023 оны 4 дүгээр сарын 18-ны зохион байгуулж хөдөө сумдын иргэдийг онлайнаар оролцох боломжийг бүрдүүлэн, албан журмын болон сайн дурын даатгуулагч, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, тэтгэвэр авагчдын төлөөллийг оролцуулан нийт 380 хүнийг хамруулсан байна. Хэлэлцүүлгийн үеэр хуулийн төсөлд өгсөн санал, тулгамдаж буй асуудал холбогдох тооцоо судалгаануудыг нэгтгэн УИХ-аас томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн болно.<br><br>Монгол улсын засгийн газрын 2022 оны 438 дугаар тогтоолд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг бүх шатны төрийн албан хаагч, ажилтнуудад таниулах гэж тусгасны дагуу ‘Алсын хараа 2050’ монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, түүний эхний үе шат ‘шинэ сэргэлтийн бодлогын богино хугацааны сургалт’ сэдэвт сургалтад нийт ажилтнуудын 70 гаруй хувийг хамрууллаа. Сургалтыг Удирдлагын академийн багш | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нар удирдан явуулж, цахим болон танхимын хосолсон сургалтад бүрэн хамрагдсан 32 албан хаагчид гэрчилгээ авлаа.<br><br>Төрийн байгууллагуудтай хамтран “Нийгмийн цогц явуулын үйлчилгээ”-г Халх гол, Сэргэлэн, Баяндун, Чойбалсан, Чулуунхороот сумдад зохион байгуулан нийт 175 хүнд нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлсэн байна. Энэхүү үйлчилгээнд эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, соёл, урлаг, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, мал эмнэлэг, улсын бүртгэл, ахуйн үйлчилгээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг олон талын үйлчилгээ багтаж байгаа юм. Үүний үр дүнд хөдөөгийн малчид нийгмийн үйлчилгээ авахын тулд сум, аймгийн төвийг зорихгүйгээр цаг хугацаа, санхүүгээ хэмнэхээс гадна аливаа өвчлөлийг эрт үед нь илрүүлэх, урьдчилан сэргийлэх, тулгамдаж буй асуудлаа шийдвэрлүүлэх боломж нэмэгдэнэ. | | |
| 4.1.6 | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг хангах ажиллах. | | Хэлтсийн ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах асуудлаар судалгаа хийх, бүртгэлжүүлэх, тусламж үзүүлэх. | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлнэ. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үр дүнг бүрэн тайлагнасан байна. | Хэлтсийн ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр Төрийн албаны тухай хууль болон Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хууль, хэлтсийн “Хөдөлмөрийн дотоод журам”, албан хаагчтай холбоотой бусад хууль тогтоомж, эрхийн актыг судлан хөтөлбөрийн төслийг боловсруулаад байна. Дээрх хөтөлбөр батлагдан хэрэгжсэнээр ажилтан, албан хаагчийн ажиллах нөхцөл бололцоог сайжруулах, | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийгмийн баталгааг хангах, чадамж боловсрол, ажлын дадлага туршлагатай мэргэшсэн хүний нөөцтэй болох зорилтуудыг хэрэгжүүлж, албан хаагчийн хувьд сэтгэл ханамжийн баталгаатай байх нөхцөл бүрдэх юм.<br><br>Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой шаардагдах хөрөнгийг хэлтсийн жил бүрийн төсөвт тусгаж байгаа боловч шаардлагатай хэмжээнд батлагдахгүй байгаа нь тулгамдаж буй асуудал болж байна. | | |
| 4.1.7 | Хэлтсийн албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх | | Хэлтсийн албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | Хэлтсийн ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах. | Ажилтан, албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж хэвшсэн байна. | Хэлтсийн 17 албан хаагчийн 2022 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгээ шинэчлэн гаргасан тайланг маягтын дагуу НДЕГ-ын холбогдох мэргэжилтэнд цаг хугацаанд нь хүргүүлсэн. Мөн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 9 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлгийг цахим хэлбэрээр авч, Авлигатай тэмцэх газарт албан бичгээр баталгааны маягтын хамт хүргүүлж, цаг хугацаанд нь хянуулахад ашиг сонирхлын зөрчил үүсээгүй байна.<br><br>Нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах, авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх талаар үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч ажиллаа.<br>*(Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийг хавсаргав)* | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | *“Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 4.2.1 | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах; | | Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамруулсан хүний тоо | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 11 удаагийн сургалтад 38 албан хаагчийг хамруулсан. | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж, албан хаагчдын мэдлэг ур чадвар дээшилсэн байна. | Байцаагч ажилтнуудын чадавхжуулах, мэргэшүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг зохион байгуулан ажиллалаа.<br><br>“Хяналт шалгалтын байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт” хэлтсийн 5 байцаагч хамрагдсан.<br><br>"Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төсөл"ийн хүрээнд хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын хяналтын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтад хамрагдсан 1 байцаагч хамрагдсан.<br><br>Прокурорын байгууллагаас 2 удаа зохион байгуулсан "Дорнод аймгийн зөрчил шалган шийдвэрлэх байгууллагуудын хамтарсан зөвлөгөөнд 10 байцаагч хамруулав.<br><br>“Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын үндсэн зорилго, зорилтыг танилцуулах дөрвөн өдрийн сургалтад нийт ажилтнууд хамрагдсанаас 23 ажилтан сертификат авсан.<br><br>Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд төрийн албан | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагчийг чадавхжуулах сургалтад нийт байцаагч ажилтнууд хамрагдсанаас 19 ажилтан сертификат авсан.<br><br>Нийгмийн даатгалын салбарын архив, албан хэрэг хөтлөлт, хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагчдын мэдлэг дээшлүүлэх сургалт, Дорнод аймгийн Архивын тасгаас зохион байгуулсан “Төрийн байгууллагуудын архив, бичиг хэргийн ажилтнууд”-ын нэгдсэн сургалтад хэлтсийн 2 ажилтан танхим болон цахимаар хамрагдсан.<br><br>Пүрэв гариг бүр төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг (7:4:10) вебинар сургалтад хэлтсийн нийт албан хаагчид тогтмол идэвхтэй оролцож байна. | | |
| 4.2.2 | Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах; | | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 6 удаагийн сургалтад 600 иргэд, даатгуулагчийг хамруулсан | Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилсэн байна. | “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн шинэчилсэн найруулга, хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор НДЕГ-ын сургалтын баг хүрэлцэн ирж, төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын дарга, хүний нөөцийн мэргэжилтэн, нягтлан бодогч, даатгуулагч иргэдэд сургалт, мэдээлэл өглөө. Тус сургалтад аж ахуйн нэгжийн 117 холбогдох албан тушаалтныг хамруулах ажлыг зохион байгуулж ажиллалаа.<br><br>Татварын байгууллагатай хамтран аж ахуйн нэгж байгууллагыг үйл ажиллагааны чиглэлээр ангилан 4 өдрийн цахим сургалт зохион байгуулахад хамтарч оролцлоо. Сургалтад байгууллагын захирал, нягтлан | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бодогч, менежерүүд зэрэг ажил олгогчийн төлөөлөл 80 гаруй хүн оролцлоо.<br>.<br>Жижиг дунд бизнес эрхлэгч иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах зорилготой "Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт” “Нийгмийн даатгалын цахим үйлчилгээ” сэдэвт сургалтыг 2 дугаар сарын 27-29-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус сургалтад ЖДҮ-н сангаас олгох зээлийн төсөлд хамрагдах хүсэлтэй 61 аж ахуйн нэгжийн төлөөлөл, жижиг дунд бизнес эрхлэгчид хамрагдлаа. Сургалтын явцад 61 аж ахуйн нэгжийн холбогдох албан тушаалтанд байгууллагын тодорхойлолт, лавлагааг цахим системээс хэрхэн авах талаар зөвлөгөө өгч ажилласан байна.<br><br>Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийг ажил олгогч байгууллагуудад сурталчлан таниулах ажлын хүрээнд Аймгийн Татварын хэлтэс,НИК ХК-ийн Дорнод салбар, ХХҮГазар, Хөгжимт драмын театрын 126 ажилтан албан хаагчдад мэдээлэл өгч холбогдох зөвлөгөөг өгч ажиллалаа.<br><br>Алслагдсан сум багийн иргэдэд нийгмийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд “Нийгмийн цогц явуулын үйлчилгээ”-г Нийгмийн даатгалын хэлтсийн зүгээс Халхгол, | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Чойбалсан, Чулуунхороот, Сэргэлэн, Баяндун сумдад хийж гүйцэтгэсэн.<br><br>Тус ажлын хүрээнд дээрх сумын ЗДТГ, Хилийн 0198-р анги, ЗХ-ий 329-р анги, Сургууль, Цэцэрлэг, Эмнэлгийн ажилтан албан хаагч болон иргэдэд Нийгмийн даатгалын багц хууль, хуульд орсон нэмэлт өөрчлөлт, хуулийн ач холбогдол хүртэх өгөөжийн талаар мөн Нийгмийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг цахимаар хэрхэн авах талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч иргэдийн асуусан асуултад хариулан зөвлөгөө мэдээллийг газар дээр шийдвэрлэн ажилласан. Тус сумдад нийт 339 ажилтан, албан хаагч, малчин, иргэдэд хүрч ажилласан.<br><br>Аймгийн засаг даргын А/327 тоот захирамжаар “Малчдын зөвлөгөөн-2023” зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу “Малчдын зөвлөгөөн-2023”-нд оролцож малчдад Нийгмийн даатгалын багц хууль, хуульд орсон нэмэлт өөрчлөлт, хуулийн ач холбогдол хүртэх өгөөжийн талаар мөн Нийгмийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг цахимаар хэрхэн авах, малчны тэтгэвэр, тэтгэмж, сайн дурын даатгалд даатгуулах талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч малчдын асуусан асуултад хариулан зөвлөгөө мэдээллийг газар дээр өгч шуурхай шийдвэрлэн ажилласан. Уг зөвлөгөөнд Халхгол, Дашбалбар, Чулуунхороот, Хөлөнбуйр, Гурванзагал сумдын 886 малчдын төлөөлөгч оролцсон. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.3 | Нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах; | | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулахаар орон нутагт зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-нд мэдээлэл байршуулсан тоо, хандалтын тоо Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, цахим хичээл, постерын тоо Хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, даатгуулагчид, ажил олгогчид мэдээлэл түгээхээр зохион байгуулсан арга хэмжээний төрөл, | Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа ны 50-аас доошгүй мэдээ, мэдээлэл бэлтгэнэ. | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээний хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд шуурхай хүргэсэн байна. | Нийгмийн даатгалын санд тухайн сардаа шимтгэлээ төлөөгүй аж ахуйн нэгжийн албан тушаалтны харилцах утсаар сануулах мессеж байгууллага аж ахуйн нэгжийн нягтлан бодогчдыг нэгтгэсэн НДХ фэйсбүүк групп чатаар сар бүр шимтгэлээ хуульд заасан хугацаанд төлөх талаар анхааруулж ажиллаж байна. Дээр үүссэн групп чатыг 233 нягтлан бодогч дагаж хууль тогтоомжтой холбоотой 126 асуултад хариулт өгч, 8 постер бэлтгэж зар сурталчилгаа зөвлөгөө мэдээллээр хангасан байна.<br><br>Дорнод” сонинтой 2023 онд хамтран ажиллах гэрээ байгуулж 0-3 насны хүүхдээ асарч буй эхийн сайн дурын даатгалын шимтгэлийн 50 хувийг хөнгөлөх, “Туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтан нийгмийн даатгалд хамрагдах тухай”, “Тоон гарын үсгээр тайлан өгөх тухай”, “Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл”, “Нийгмийн даатгалд даатгуулах ач холбогдол”, “Сайн дурын даатгал” зэрэг сэдвээр мэдээлэл бэлтгэн 6 удаа сонинд нийтлүүлэв.<br><br>Мөн орон нутгийн ТВ6 телевизтэй хамтран сайн дурын даатгалын талаар хариуцсан байцаагч 2 удаа мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн байна. Мөн хэлтсийн вэб сайтад ирсэн сайн дурын даатгалын холбогдолтой 12 асуултад хариулт өгч ажиллав. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сурталчилгаа хийсэн тоо<br>Зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн сурталчил-гааны тоо, төрөл | | | “Дорнод Нийгмийн даатгал” вэб сайтад ирсэн сайн дурын даатгалын талаарх иргэдийн асуултад хариулан шаардлагатай тохиолдолд утсаар нь холбогдон 193 даатгуулагч иргэнд сайн дурын даатгалын тооцоо, шимтгэл төлөлтийн талаарх мэдээлэл өгөв. Үүнд:<br>➢ Сайн дурын даатгалын шимтгэл төлөх хэлбэр-66<br>➢ Цахимаар даатгуулж гэрээ байгуулах тухай -56<br>➢ Сайн дураар даатгуулагчийн гэрээгээр хүлээсэн шимтгэл төлөх үүргээ биелүүлээгүй-29<br>➢ Шимтгэл төлөлтийн төлбөр тооцооны тухай-42<br><br>Нийгмийн даатгалын ерөнхий газраас нийтэлж байгаа постер мэдээллийг Дорнод сайн дурын даатгуулагч фейсбүүк групп, хуудсаар түгээн ажиллаж байна. Оны эхнээс 15 чиглэлээр мэдээлэл түгээсэн байна. Тухайлбал:<br>➢ Шинэчлэн найруулсан “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн, тэтгэмжийн, ҮОМШӨ-ний тухай хуулийн агуулга<br>➢ Сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд.<br>➢ 0-3 насны хүүхдээ асарч буй ээжүүдэд сайн дурын даатгалаа хөнгөлөлттэй нөхцөлөөр даатгуулах тухай гэх мэт. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хэлтсийн лавлах утасны “Call center” үйлчилгээгээр ирж буй дуудлага бүрд хариу өгч ажиллаж байна. Өдөрт энгийн үед 10-15 дуудлага, сар улирлын сүүлчийн өдрүүдэд ачаалал нэмэгдэн өдөрт 20-35 дуудлагад тогтмол хариу мэдээлэл өгч байна. “Call center” үйлчилгээгээр ирж буй дуудлагуудын асуултыг ангилж үзэхэд:<br>✓ Сайн дурын даатгалын шимтгэлийг цахимаар хэрхэн төлөх,<br>✓ Сард хэдэн төгрөг төлөх,<br>✓ Шимтгэл төлсөн сараа мартсан тул шалгуулах,<br>✓ Регистрийн дугаараа буруу бичиж шимтгэлээ төлснөөс гарсан алдаанууд залруулах,<br>✓ Дансны дугаар тодруулах зэрэг асуултууд дийлэнх хувийг эзэлж байна.<br><br>“Нийгмийн даатгал” пэйж хуудсанд “Чат бот” үйлчилгээгээр ирж буй сайн дурын даатгалтай холбоотой асуултад холбогдох мэдээллийг шалган хариу өгч ажиллаж байна. Уг үйлчилгээгээр сард дунджаар 40-60 даатгуулагчид мэдээлэл хүргэж 396 хүнд зөвлөгөө өгсөн байна.<br><br>Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг нэмэгдүүлэх үүднээс Худалдаа хөгжлийн банкны Дорнод салбар болон ХААН банкны данс хариуцсан ажилтантай холбогдон сайн дурын даатгалын шимтгэлээ өөрийн данснаас сар бүр | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтмол татуулах үйлчилгээний талаар мэдээлэл зөвлөгөө авч, сайн дурын даатгалын гэрээтэй болон шинээр хамрагдан гэрээ байгуулахаар хүсэлт гаргаж буй иргэдэд мэдээлэл өгч сар бүр тогтмол шимтгэлээ онлайнаар төлөх нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна. Уг ажлыг зохион байгуулснаар 251 даатгуулагч дансаа холбуулсан байна.<br><br>"Дорнод аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс" пэйж хуудсаар дамжуулан иргэдээс ирүүлсэн асуултыг дор бүр нь хариултыг өгч ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар 356 иргэдийн асуултад хариулж зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан. | | |
| | *“Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 4.3.1 | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллах | Зохион байгуулалтын арга хэмжээ | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төрөлжсөн мэргэжлийн эмч нар нь үечилсэн дүгнэлтэд жилд 2-оос доошгүй удаа үнэлгээ хийсэн байна. | Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭХМТК-т хүргүүлсэн байна. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төрөлжсөн мэргэжлийн эмч нар нь үечилсэн дүгнэлтэд үнэлгээ хийж эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар хэлэлцүүлсэн үечилсэн дүгнэлтийн 30-аас доошгүй хувийг хамруулсан байна. | Хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төрөлжсөн мэргэжлийн эмч нар 46 удаагийн хурлаар 1467 иргэний амбулаторийн картын үечилсэн дүгнэлтийг хянан хэлэлцэн 51 иргэнийг буцаах арга хэмжээ авч, 12 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэв.<br><br>Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтыг төрөлжсөн мэргэжлийн эмч нар тогтмол хянаж, оношийн бүрдэл дутуу, баталгаажилт | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад жилд 4-өөс доошгүй удаа хяналт хийсэн байна. | | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад хяналт хийж холбогдох арга хэмжээ авсан байна. | хангалтгүй 39 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг түдгэлзүүлэх арга хэмжээ авав.<br><br>Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын 46 удаагийн хурлаар шийдвэрлэсэн нийт 3096 иргэний мэдээллийг комиссын мэдээллийн санд үнэн, зөв бүрдүүлсэн эсэхэд тогтмол хяналт тавин ажиллав. Хяналтын явцад хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, оношийн код, заалт буруу 25, өвчний ангилал буруу 3, хурлын төлөв буруу сонгосон 6 тохиолдлыг тус тус илрүүлэн, залруулах арга хэмжээ авав.<br><br>Түүнчлэн тэтгэврийн массивыг, комиссын хурлын мэдээллийн сантай тулган, сайн дурын даатгалын шимтгэлийг 3 жил төлж халамжаас нийгмийн даатгал руу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврээ шилжүүлсэн 25, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 9, бусад аймаг, дүүргээс шилжиж ирсэн 10, шилжиж явсан 18, нас барсан 81 иргэний хөдөлгөөнийг мэдээллийн санд бүртгэв.<br><br>Комиссын хурлын үед хийгдсэн хөдөлгөөний мэдээллийг тухай бүр хянаж, хурал бүрийн дараа эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын ehmkweb программд файлаа илгээж байна. *(46 удаа)* | | |
| | | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд хагас жил тутам тулгалт хийсэн байна. | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд тулгалт хийж цахим мэдээллийн санг бүрдүүлсэн байна. | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг хагас жил тутам зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | Засгийн газрын 2021 оны 67 дугаар тогтоолыг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хамтарсан ажлын хэсэг хэлтсийн дэргэдэх эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаа, хөдөлмөрийн чадвар алдалт тогтоож байгаа үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх ажлыг 2023 оны 03 дугаар сарын 27-31-ний өдрүүдэд зохион байгуулсан.<br>Манай аймгийн нийт 14 сумаас хөдөлмөрийн чадвар алдалт хамгийн өндөр Хөлөнбуйр (5.3%), Булган (4.7%), Баянтүмэн (4.5%), Сэргэлэн (4.5%) сум болон аймгийн төвд ажлын хэсэг тус тус ажиллав. Ажлын хэсгийн гишүүн Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналт шалгалтын газрын улсын ахлах байцаагч, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын магадлагч эмчтэй хамтран түүврийн аргаар шалгалтад орох иргэдийн жагсаалтын дагуу 78 иргэнийг хяналт шалгалтад хамруулав.<br>Ажлын хэсэг аймгийн Засаг даргын орлогчтой уулзалт хийж, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаа, хөдөлмөрийн чадвар алдалтын талаарх нэгдсэн мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэж арга хэмжээ авч ажиллах, аймгийн Эрүүл мэндийн газар, БОЭТ, сумдын Засаг дарга нар, сумдын эмнэлэгт холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөх, хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон иргэдийг | | |
| 4.3.2 | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах арга хэмжээ зохион байгуулсан байх | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байна | Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭХМТК-т хүргүүлсэн байна. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгуулж эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадвар сайжирч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үйл ажиллагаа ижил түвшинд хүрсэн байна. | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд сайн туршлага нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд сайн туршлага нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж туршлага солилцсон байна. | нөхөн сэргээх, эмчлэн эрүүлжүүлэх, хөдөлмөрийн чадвар алдсан хүний тоог бууруулах талаар анхаарч ажиллах чиглэл өгөв.<br><br>Хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар хэлэлцэж буй хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох, сунгах явцад оношийн үндэслэл хангалтгүй, давтан үзлэг, шинжилгээ хийлгэх шаардлагатай 6 иргэнд сэтгэц, мэдрэл, хавдар, чих хамар хоолойн ижил мэргэжилтний үзлэгийг хийлгэж, дүгнэлтийг үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэлээ.<br>Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагааны сайн туршлагын мэдээллийг цахим уулзалтаар сонсож танилцан туршлага солилцов. | | |
| 4.3.3 | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын оролцогч талуудын үйл ажиллагаag нэгтгэх | | Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах жилийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэн ажиллана.<br><br>Орон нутгийн | Төлөвлөгөө-ний хэрэгжилтийн болон судалгааны тайланг ЭХМТК-т хүргүүлнэ. | Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах төлөвлөгөө гарган, хэрэгжүүлсэн байна. | Хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, хяналт сайжруулах ажлын төлөвлөгөөг гарган батлуулсан ба хэрэгжилт 91.7 хувийн биелэлттэй байна.<br><br>Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолтыг өмнөх оны байдалтай харьцуулахад 101 иргэнээр буюу 2.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.<br><br>Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолтыг сүүлийн 3 жилийн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгаа хийж, тодорхой арга хэмжээ авч орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагад танилцуулсан байна. | | Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгаатай болсон байна. | байдлаар (2021-2023 он) авч үзэхэд жил бүр 2.4-4.5 хувиар тогтмол буурч байгаа боловч аймгийн нийт хүн амын тоонд харьцуулахад улсын дунджаас өндөр үзүүлэлттэй байна. Аймгийн нийт хүн амын 4.4 хувийг хөдөлмөрийн чадвар алдсан иргэд эзэлж байна. (Улсын дундаж 3.1%, хүн амын тоо 84650)<br><br>Хөдөлмөрийн чадвар алдалтыг шалтгаанаар нь авч үзвэл:<br>➢ ердийн өвчнөөр 41.5%,<br>➢ төрөлхийн 27.3%,<br>➢ ахуйн ослоор 19.9%,<br>➢ хүүхэд насандаа 10.5%,<br>➢ үйлдвэрлэлийн ослоор 0.8% тус тус эзэлж байна. | | |
| | | | | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлж Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссыг хурлын байраар хангах, тохижуулах ажлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, сургалт сурталчилгаа хийх нөхцөлийг бүрдүүлэх, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх тоног төхөөрөмжөөр | Хөдөлмөрийн чадвар алдалтын шинэ тогтоолтын 90 орчим хувийг дотрын өвчин (32.3%), хорт хавдар (21.8%), гэмтэл согогийн өвчин (15.8%), сэтгэцийн эмгэг (12%), нүдний өвчин (6.8%) эзэлж байна. Дотрын өвчний заалтаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолтын 55.6 хувийг элэгний хатуурал, чихрийн шижин өвчин эзэлж байна. Нийт сунгалтын 82.2 хувийг сэтгэц, дотор, гэмтэл согог, нүд, чих хамар хоолойн өвчин эмгэг эзэлж байна.<br><br>Аймгийн Засаг даргад болон Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд хөдөлмөрийн чадвар | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна. | | хангах зэрэг ажлыг зохион байгуулсан байна. | алдалтын хувь хугацаа тогтоолтын 2022 оны жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, судалгааны хамт хэлтсийн даргын 2023 оны 39, 82 тоот албан бичгээр тус тус хүргүүлэв.<br><br>Хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлын үйл ажиллагаа Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн амбулаторийн өрөөнд явагдаж байна.<br><br>Цаашид хурлын өрөөний тохижилт, орчны ая тухтай байдал, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж, сайжруулах шаардлагатай байгааг аймгийн Засаг даргад уламжилсан болно. | | |
| 4.3.4 | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаарх хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна. | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо, тайланг хүргүүлсэн бай | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын болон Эмнэлэг хяналтын комиссын гишүүд, төрөлжсөн мэргэжлийн, сумын, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн чиглэлээр сургалт зохион байгуулж шинэ мэдээ, мэдээллийг | Хэлтсийн магадлагч эмч Засгийн газрын 2021 оны 67 дугаар тогтоолоор баталсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”, Эрүүл мэнд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/758, А/197 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн өвчний жагсаалт”-ын талаарх мэдээ мэдээллийг 2023 оны 01 дүгээр сард хүргэв. Уг мэдээлэлд Асралт үйлс, Мянган жаргалан, Ягаан цээнэ өрхийн эрүүл мэндийн төвийн 23 эмч мэргэжилтнүүд хамрагдлаа.<br><br>Төрөлжсөн мэргэжлийн эмч нар болон өрхийн эрүүл мэндийн төвийг Эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой тогтоол, шийдвэрийн шинэчилсэн эмхэтгэл | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүргүүлж ажилласан байна. | номоор хангаж ажиллав. | | |
| | | | Эмнэлэг хяналтын комиссын гишүүд, төрөлжсөн мэргэжлийн, сумын, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна. | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын болон Эмнэлэг хяналтын комиссын гишүүд, төрөлжсөн мэргэжлийн, сумын, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан байна. | Хэлтсийн магадлагч эмч 3 өрхийн эрүүл мэндийн төвийн 23 эмч мэргэжилтнүүдэд эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм, даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн өвчний жагсаалтын талаар болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгч ажиллав.<br><br>Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс болон Эмнэлэг хяналтын комиссын нийт 11 гишүүд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалтад цахимаар хамрагдав.<br><br>Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүр зохион байгуулдаг ТАЗ 7:4:10 "Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн орчин" сэдэвт сургалтад Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, Эмнэлэг хяналтын комисс, сумын эрүүл мэндийн төвийн нийт 34 хүн хамрагдлаа. | | |
| | *“Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 4.4.1 | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, даатгуулагчийн мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хангах | | Тухайн онд идэвхтэй шимтгэл төлөгч даатгуулагчийн регистрийн дугаар улсын | 2022 онд даатгуулагчийн регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн сантай | Нийт даатгуулагчийн регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн регистрийн дугаартай нийцсэн | Нийгмийн даатгалын хэлтэст шимтгэл төлөгчөөр бүртгэгдсэн 301 ажил олгогчийн мэдээллийн баазын бүртгэлд хяналт хийж ажиллалаа.Үүнд:<br>1. Ажил олгогчийн улсын бүртгэлийн хаяг өөрчлөгдсөн - 1 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүртгэлийн мэдээллийн регистрийн дугаартай 100% нийцсэн байна. | 99.92% нийцсэн. | байна. | 2. Байгууллагын үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн - 0<br>3. Байгууллагын захирал /эзэн холбогдогч/, нягтлан бодогч нь өөрчлөгдсөн - 12<br>4. Үйл ажиллагаагаа зогсоосон – 25 байгууллагын нөхцөл байдлыг судалж, мэдээллийн баазыг шинэчлэн ажиллалаа. | | |
| | | | Тухайн онд идэвхтэй шимтгэл төлөгч даатгуулагчийн овог /эцэг, эхийн нэр/ улсын бүртгэлийн мэдээллийн овог /эцэг, эхийн нэр/-той 100% нийцсэн байна. | 2022 онд даатгуулаг-чийн овог /эцэг, эхийн нэр/ улсын бүртгэлийн мэдээллийн сантай 99.62% нийцсэн. | Нийт даатгуулагчийн овог /эцэг, эхийн нэр/ улсын бүртгэлийн мэдээллийн овог /эцэг, эхийн нэр/-тэй нийцсэн байна. | Даатгуулагчийн овог нэр өөрчилсөн 6, регистрийн дугаар өөрчлөгдсөн 4 мэдээллийг хүлээн авч http://10.9.0.5/regweb// цахим мэдээллийн сангаас тулган баталгаажуулж мэдээллийг засварласан.<br>Эхний хагас жилийн байдлаар даатгуулагчийн ID давхардсан 104 даатгуулагчийн мэдээллийг нэгтгэж мэдээллийн сангийн үнэн зөв байдлыг ханган ажиллалаа. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Тухайн онд идэвхтэй шимтгэл төлөгч даатгуулагчийн нэр улсын бүртгэлийн мэдээллийн нэртэй 100% нийцсэн байна. | 2022 онд даатгуулагчийн нэр улсын бүртгэлийн мэдээллийн нэртэй 99.95% нийцсэн. | Нийт даатгуулагчийн нэр улсын бүртгэлийн мэдээллийн нэртэй нийцсэн байна. | Нийгмийн даатгалын мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулах, даатгуулагчийн алдаатай бүртгэлийг залруулахад онцгой анхаарч регистрийн дугаар зөрүүтэй 19 даатгуулагчийн мэдээллийг залрууллаа. Ингэснээр төрийн мэдээлэл нь хоорондоо зөрөхгүй, иргэдэд үзүүлэх үйлчилгээ түргэн шуурхай, үнэн, бодитой байх боломж нөхцөл бүрдүүлэх юм.<br><br>Дорнод аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллийн санд 1800 гаруй аж ахуйн нэгж бүртгэлтэй боловч 970 ажил олгогч байгууллага нийгмийн даатгалын шимтгэл төлж сар улиралдаа тайлагнан ажиллаж байна. | | |
| | | | Өмнөх онуудад шимтгэл төлж байсан даатгуулагчдын овог, нэр, регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн сантай 95% нийцсэн байна. | | Өмнө онуудад шимтгэл төлж байсан даатгуулагчийн мэдээлэл улсын бүртгэлийн мэдээлэлтэй нийцсэн байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийг анх бүртгэхдээ нэр, бүртгэлийн дугаар давхардаж байгаа эсэхийг шалган, өмчийн хэлбэр, хаяг байршил, удирдах болон холбогдох ажилтны утасны дугаар, цахим хаяг, харилцагч банк, дансны дугаар зэргийг бүрэн гүйцэд бүрдүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна<br><br>Түүнчлэн шимтгэл төлөгч аж ахуйн нэгж байгууллагын өмчийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, хаяг байршлын өөрчлөлтийг цаг тухайд нь шинэчлэн ажиллаж байна. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4.2 | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | | Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байна. | 2022 онд ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.92% байсан. | Ажил олгогчийн үндсэн мэдээлэл буюу ЭЗҮАСА, өмчийн болон хариуцлагын хэлбэр, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна. | Ажил олгогч байгууллагын эдийн засгийн үйл ажиллагааны чиглэл, салбартай, салбаргүй, толгой байгууллага эсэхийг ***opendata.burtgel.gov.mn*** вэб программтай 58 үйл ажиллагааны чиглэлийг шинэчилсэн байна.<br><br>Мөн байгууллагын шилжиж ирсэн, шилжиж явсан хөдөлгөөнийг хянаж шалгалаа.<br>Үүнд :<br>• Шилжиж ирсэн 80 байгууллага<br>• Шилжиж явсан 60 байгууллага<br>• Регистрийн дугаар буруу 4 байгууллагын хөдөлгөөнийг тус тус шинэчлэн ажиллалаа. | | |
| | | | Ажил олгогчийн НДШ-ийн тайланд иргүүлэх даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүрдүүлсэн байна. | | -Даатгуулагчийн үндсэн мэдээллийг зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн төрлийг зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн улсын кодыг зөв хүлээн авсан байна.<br>- Тухайн ажил олгогч дээр нэг сар дээр нэг даатгуулагчийг нэгээс илүүгүйгээр тайланд тусгуулсан байна. | НДЕГ-ын даргын “Гадаадын иргэдийн бүртгэлийн дугаарыг өөрчлөх тухай” албан бичгийн хавсралтад аймгийн хэмжээнд 17 байгууллагын 246 гадаад иргэний регистрийг шинэчлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа. Үүнээс үйл ажиллагаа нь зогссон Шанлун ХХК, Энержи трак ХХК, Ундран бэхжих ХХК тус тус байгууллагын гадаад иргэний бүртгэл шинэчлэн бүртгэх боломжгүй байна.<br>Албан бичгийн хугацаанд нийт 144 гадаад иргэний мэдээллийг засахаас 95 гадаад иргэний мэдээллийг шинэчлэн шимтгэлийн цахим системд бүртгэж ажиллаж байна. | | |
| | | | Ажил олгогчоос | | Ажил олгогчоос цахимаар иргүүлэх | Нийгмийн даатгалын шимтгэлийн цахим системд хөдөлмөрийн харилцаа үүсэж, | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байна. | | тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байна. | ажилд орсон болон ажлаас чөлөөлөгдөж байгаа мөн ажил албан тушаалд өөрчлөлт орсон ажилтан албан хаагчдын тушаал шийдвэрийг тухай бүрд нь оруулж байх талаарх мэдээллийг ажил олгогч байгууллагуудад тогтмол зөвлөж байна. 2023 онд хийгдсэн ажил олгогчийн 12 удаагийн сургалтад дээрх мэдээллийг тогтмол өгч ажилласан. | | |
| 4.4.3 | Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх | | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгээгүй байна. | 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 550,000 төгрөг болж өөрчлөгдсөнтэй холбогдуулан 06, 17, 25, төрөлтэй даатгуулагчдын хөдөлмөрийн хөлсний хэмжээг 420,000 төгрөгөөр буруу тайлагнаж ирүүлснийг хуульд орсон өөрчлөлтийг танилцуулан зөвлөж, хөдөлмөрийн хөлсийг засварлуулан ажиллалаа.<br><br>Даатгуулагчийн ***68, 69, 70, 71, 02*** төрлүүд шинээр нэмэгдэж, шимтгэлийн цахим системд өөрчлөлт орсон тухай албан бичгийн хүрээнд байгууллагын холбогдох албан тушаалтанд мэдээлэл хүргүүлэн ажилласан. Уг ажлын хүрээнд шимтгэлийн тайлан хүлээн авахдаа 22 төрөлтэй тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгон ажиллаж байгаа 264 ажилтны шимтгэл төлөх төрлийг 70 болгон өөрчилсөн байна.<br><br>Мөн албан журмын болон сайн дурын даатгалын шимтгэл төлөлт давхардсан хугацааг шүүж холбогдох нотлох баримтад үндэслэн дараагийн сард шилжүүлэх, | | |
| | | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгээгүй байна. | | | |
| | | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна. | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийгээгүй байна. | | | |
| | | | Цахим хяналтын программ хангамжаар илэрч буй | | Цахим хяналтын программ хангамжаар илэрч буй алдааг 100% нягталж | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | алдааг 100% нягталж залруулсан байна. | | залруулсан байна. | буцаан олгох ажлуудыг 12 даатгуулагчидтай хийж тооцоо нийллээ.<br><br>Сайн дурын даатгалыг сар давхардуулан хийсэн тооцоо байхгүй болно. | | |
| 4.4.4 | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах | | Нэгжийн дотоод сүлжээ, техник хангамжийн хэвийн ажиллагаа хангагдсан байна. | Нэгжийн дотоод сүлжээ, техник хангамжийн үйл ажиллагаа хэвийн явагдсан. | | Нийгмийн даатгалын байгууллага салбарын хэмжээнд болон орон нутгийн нийгмийн даатгалын хэлтэс, сумын байцаагчийн мэдээллийн аюулгүй байдал хангах үүднээс улирал байцаагч ажилтнуудын компьютер, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, дотоод сүлжээний аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.<br><br>2023 он гарсаар тэтгэврийн программд 10 удаа, тэтгэмжийн програмд 2 удаагийн өөрчлөлт орсон цаг тухайд нь суулган програм хангамжийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.<br><br>“Сервер компьютерийн оны эцсийн үйлчилгээний журам”-ыг хэрэгжүүлэн улирал тутамд албан хаагчийн компьютерийн нууц үг болон программ хангамжийн нууц үгийг шинэчлэн ажилласан. Мөн нэгжид ашиглагдаж буй 10 программыг цаг тухай бүрд тогтмол шинэчлэлт өөрчлөлтийг хийж ашиглагдаж буй сервер компьютерийн аюулгүй байдал урьдчилан сэргийлэх талаар анхаарч ажиллаж байна.<br><br>Мэдээлэл тооцооллын төвөөс 11 сарын | | |
| | | | Программ хангамжуудыг зөв зохистой ашиглаж буй байдал, нэгжид ашиглагдаж буй программ хангамжуудын шинэчлэлт өөрчлөлт цаг хугацаандаа хийгдсэн байна. | Нэгжид ашиглагдаж буй программ хангамжууды н шинэчлэлт, өөрчлөлтийг цаг хугацаанд нь хийсэн. | Нэгжийн дотоод сүлжээ, техник хангамж, серверийн найдвартай ажиллагаар хангаж гэмтэл, саатал гарсан тохиолдолд түргэн шуурхай илрүүлж хэвийн ажиллагаар хангах арга хэмжээг авсан байна. | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлаар нийт 18 удаагийн албан бичиг зааврыг мөрдөн ажиллаж байна.<br><br>Сумдын байцаагч нарт зайнаас цахимаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зориулалтаар НДЕГ-ын Мэдээлэл технологийн төвөөс сар бүр 60GB дата ашиглах эрх бүхий хөдөлгөөнт интернэтийн төхөөрөмжөөр ханган ажиллаж байна. | | |
| | | | МТТ-өөс батлан мөрдүүлж буй “Сервер компьютерийн оны эцсийн үйлчилгээний журам”-ыг хэрэгжүүлсэн байна. | Оны эцсийн үйлчил-гээний журмын хэрэгжилт хангагдсан. | Нэгжид ашиглагдаж буй программ хангамжуудын шинэчлэлт, өөрчлөлтийг цаг тухайд нь хийж байцаагч ажилтнуудын ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 2023 онд анхан шатны нэгжид ашиглагдаж буй программ хангамжуудын шинэчлэлт, өөрчлөлтийг цаг тухайд нь хийж байцаагч ажилтнуудын ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа. Тухайлбал:<br><br>• Тэтгэврийн программд 5 удаа,<br>• Тэтгэмжийн программд 1 удаагийн өөрчлөлт орсон цаг тухайд нь суулган программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. | | |
| | | | МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байна. | | Нэгжийн сервер компьютерийн оны эцсийн тохируулга үйлчилгээг журмын дагуу бүрэн хийж тайланг цаг хугацаанд нь баталгаажуулан МТТ-д ирүүлсэн байна. | Нийгмийн даатгалын сангийн жилийн эцсийн тайлан дуусаж, оны эцсийн үйлчилгээг холбогдох журамд заасны дагуу нэг бүрчлэн шалгаж хаалт хийлгэж байгаа болно. Журмын дагуу тооцоо нийлсэн актыг баталгаажуулан хүргүүлсэн болно. | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА Д.АРИУНБОЛД

..............................................................

(2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр)